



藏文書寫

# ХҮН АМ, ОРОН СҮҮЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО

# ОНДОР НАСТАН



A color photograph of a family of three. The father, wearing glasses, a white shirt, and a maroon tie, is smiling at the camera. The mother, with dark hair, is also smiling. In front of them, a young child with short hair is looking directly at the camera with a neutral expression.

A photograph of two young women in graduation gowns and caps, smiling and holding diplomas.

A blue truck is shown from a side-front angle, heavily loaded with various items, including large rolls of patterned fabrics and boxes. A person wearing a traditional cap and jacket stands behind the truck, looking towards the camera. The background shows a clear sky and some distant hills.

A portrait of a construction worker wearing a green hard hat and a red jacket, standing next to a vertical steel beam.

Год	Официальный прогноз	Демографический прогноз	Исторический тренд
2010	2.2	2.2	2.2
2020	3.0	2.8	2.8
2030	4.0	3.5	3.5
2040	5.8	4.8	4.8



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

## ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО

ӨНДӨР НАСТАН

Улаанбаатар хот  
2011 он

DDC  
305.26'021'517  
Θ-818

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,  
Засгийн газрын III байр  
<http://www.nso.mn>  
И-мэйл: nso@magicnet.mn

Сэдэвчилсэн судалгаанд тусгасан дүгнэлт, зөвлөмж нь уг судалгааг бичиж  
боловсруулсан судлаачдын дүгнэлт, санал болно.

Энэхүү судалгаа нь англи хэл дээр хэвлэгдэж, хэрэглэгчдийн хүртээл болно.

ISBN 978-99929-64-74-X

## АГУУЛГА

Сэдэвчилсэн судалгаа бичихэд оролцогчид .....	4
Хүснэгтийн жагсаалт .....	5
Зургийн жагсаалт .....	6
Хавсралт хүснэгтийн жагсаалт .....	7
Өмнөх үг .....	9
<b>БҮЛЭГ 1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, БҮТЭЦ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ</b>	
1.1. Судалгааны зорилго .....	12
1.2. Ойлголт, тодорхойлолт .....	13
1.3. Судалгааны бүтэц, агуулга .....	16
<b>БҮЛЭГ 2 ӨНДӨР НАСТНЫ ТОО, ӨСӨЛТ, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ</b>	
2.1. Өндөр настны тоо, өсөлт, нас, хүйсийн бүтэц .....	18
2.2. Өндөр настны хүйсийн харьцаа, насжилтын индекс, голч нас .....	24
2.3. Хүн ам зүйн ачаалал, түүний чиг хандлага .....	25
<b>БҮЛЭГ 3 ӨНДӨР НАСТНЫ ГЭР БУЛИЙН БАЙДАЛ, СУУЦНЫ НӨХЦӨЛ</b>	
3.1. Өндөр настны гэр булийн байдал .....	28
3.2. Өндөр настны өрхийн тэргүүлэгчийн хамаарал, өрх .....	31
3.3. Өндөр настны сууцны төрөл, нөхцөл .....	33
<b>БҮЛЭГ 4 ӨНДӨР НАСТНЫ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>	
4.1. Өндөр настны үндэс угсаа .....	42
4.2. Өндөр настны бичиг үсгийн мэдлэг, боловсролын төвшин .....	45
4.3. Өндөр настны эдийн засгийн идэвх .....	50
4.4. Өндөр настны ажил эрхлэлт, ажил мэргэжлээр .....	55
4.5. Өндөр настны ажил эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар .....	59
4.6. Өндөр настны ажил эрхлэлт, боловсролын байдлаар .....	60
4.7. Хөгжлийн бэрхшээлтэй өндөр настан .....	62
4.8. Өндөр настны интернет, гар утасны хэрэглээ .....	67
Дүгнэлт, зөвлөмж .....	69
Ашигласан материал .....	74
Хавсралт .....	75



## СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГАА БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

### НЭГ. СУДАЛГААГ БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН

#### Юмсурэнгийн Туул

Эдийн засгийн ухааны доктор  
“Эдикайшн” сургалт, судалгааны төвийн судлаач, статистик эдийн засагч, ахлах статистикч,

#### Жамбын Цэндсүрэн

Эдийн засагч  
“Эдикайшн” сургалт, судалгааны төвийн судлаач, Монголын ахмадын холбооны ерөнхийлөгч

#### Нямдашийн Батсайхан

Эдийн засгийн ухааны доктор  
“Эдикайшн” сургалт, судалгааны төвийн судлаач, Дублины Их сургуулийн багш

#### Туулын Энхжин

Олон улсын мэргэшсэн нягтлан, ACCA, магистр  
“Эдикайшн” сургалт, судалгааны төвийн дарга, судлаач,

#### Оюунцэцэгийн Болормаа

Эдийн засагч  
“Эдикайшн” сургалт, судалгааны төвийн судлаач, Улаанбаатар дээд сургуулийн Бизнес, сургалт, судалгааны төвийн мэргэжилтэн

#### Банзрагч Оюун

Боловсролын Их Сургуулийн Докторант  
“Эдикайшн” сургалт, судалгааны төвийн судлаач

### ХОЁР. ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН

#### Цэнджавын Бадрах

Эдийн засагч  
ҮСХ-ны MNG4P103 төслийн зөвлөх

#### Жигжидсүрэнгийн Ядамсүрэн

Санхүү-Эдийн засагч  
Эдийн засгийн ухааны доктор, профессор

### ГУРАВ. ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

#### Ганбаатарын Урангоо

Бизнесийн удирдлага, санхүүгийн менежер  
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны шинжээч

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1	Өндөр настны тоо, жилийн дундаж өсөлт, 1956-2010 он .....	18
Хүснэгт 2.2	Өндөр настны тоо, өсөлт, насны бүлэг, хувиар, 1989, 2000, 2010 он.....	19
Хүснэгт 2.3	Өндөр настны тоо, нийт хүн амд эзлэх хувь, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр, 2000, 2010 он.....	20
Хүснэгт 2.4	Өндөр настны тоо, хот, хөдөө, насны бүлэг, хувиар, 2000, 2010 он.....	23
Хүснэгт 2.6	Шилжин суурьшсан өндөр настны тоо, насны бүлэг, хот, хөдөө, хувиар, 2000, 2010 он.....	24
Хүснэгт 2.7	Өндөр настны хүн ам зүйн үндсэн зарим үзүүлэлтүүд, 1989, 2000, 2010 он .....	24
Хүснэгт 2.8	Хүн ам зүйн ачаалал, 2000, 2010 он .....	25
Хүснэгт 3.1	Нийт хүн амын болон өндөр настны гэр бүлийн байдал, хүйс, хувиар, 2000, 2010 он.....	28
Хүснэгт 3.2	Өндөр настны гэр бүлийн байдал, нас, хүйс, хот, хөдөө, хувиар, 2010 он.....	29
Хүснэгт 3.3	Өндөр настны өрх, өрхөд тоологдсон хүний тоо, өрхийн хэлбэр, хот, хөдөө, хувиар, 2000, 2010 он .....	32
Хүснэгт 3.4	Байшинд амьдардаг, өндөр настай өрхийн тоо байшингийн төрөл, өмч, эзэмшилийн хэлбэр, хот, хөдөө, хувиар 2010 он.....	34
Хүснэгт-3.5	Байшинд амьдардаг өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн тоо, байшингийн төрөл, өмч, эзэмшилийн хэлбэр, хот, хөдөөгөөр, 2010 он .....	35
Хүснэгт- 3.6	Өндөр настан тэргүүлэгчтэй, байшинд амьдардаг өрхийн байшингийн төрөл, халаалтын эх үүсвэр, хувиар, 2010 он.....	36
Хүснэгт 3.7.	Байшинд амьдардаг өндөр настан тэргүүлэгЧтэй өрхийн ундны усны хангамж, байшингийн төрөл, ундны усны эх үүсвэр, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	38
Хүснэгт 4.1	Нийт хүн ам, өндөр настны улсын харьялал, үндэс угсаа, хүйс, дүнд эзлэх хувиар, 2000, 2010 он.....	42
Хүснэгт 4.2	Өндөр настны үндэс угсаа, нас, хүйс, хувиар, 2010 он .....	43
Хүснэгт 4.3	Өндөр настны шүтлэгийн байдал, насны бүлэг, шашны төрөл, хувиар, 2010 он.....	44
Хүснэгт 4.4	Өндөр настны бичиг үсгийн мэдлэг, боловсролын төвшин, хүйс, дүнд эзлэх хувиар, 1989, 2000, 2010 он .....	45
Хүснэгт 4.5	Өндөр настны бичиг үсгийн мэдлэг, боловсролын төвшин, нас, хүйс, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	46
Хүснэгт 4.6	Өндөр настны ажиллах хүчний оролцооны төвшин, хүйс, хот, хөдөө, хувиар, 2010 он.....	50
Хүснэгт 4.7	Өндөр настны ажил эрхлэлтийн байдал, насны бүлэг, хүйс, хот, хөдөө, хувиар, 2010 он.....	51
Хүснэгт 4.8	Ажил эрхэлдэг өндөр настан, насны бүлэг, хүйс, хот, хөдөө, хувиар 2010 .....	54
Хүснэгт 4.9	Тэтгэвэр, нөхөн олговор авч байгаа өндөр настан, боловсролын байдал, хүйс, хот, хөдөө, хувиар, 2010 он.....	55
Хүснэгт 4.10	Ажил эрхэлж буй өндөр настны тоо, ажил мэргэжлийн ангилал, насны бүлэг, хүйс, хот, хөдөө, хувиар 2010 он.....	56
Хүснэгт 4.11.	Ажил эрхэлдэг өндөр настны тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хот, хөдөө, хувиар, 2010 он.....	59



Хүснэгт 4.12.	Ажил эрхэлдэг өндөр настны ажил эрхлэлтийн байдал (статус), насны бүлэг, хот, хөдөө, хувиар, 2010 он.....	61
Хүснэгт 4.13.	Хөгжлийн бэрхшээлтэй өндөр настны тоо, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хүйс, хувиар, 2010 он.....	62
Хүснэгт 4.15.	Хөгжлийн олдмол бэрхшээлтэй өндөр настны тоо, нас, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хүйс, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	64
Хүснэгт 4.16.	Хөгжлийн бэрхшээлтэй өндөр настны тоо, гэр бүлийн байдал, хувиар, 2010 он.....	66

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1	Хүн амын нас, хүйсийн суварга, 2000, 2010 он .....	19
Зураг 2.2	Нийт хүн амд 0-14, 60, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувийн жин.....	22
Зураг 2.3.	Өндөр настны хүйсийн харьцаа, насны бүлгээр, 2000, 2010 он .....	25
Зураг 3.1	Нийт өндөр настанд бэлбэсэн өндөр настны эзлэх хувь, нас, хүйсээр, 2000, 2010 он.....	28
Зураг 3.3	Өндөр настны өрх, өрхөд тооллогдсон хүний тоо, хот, хөдөө, хувиар, 2010 он.....	33
Зураг 3.4	Байшинд амьдардаг, өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн сууцны төрөл, хот, хөдөө, хувиар 2010 он.....	34
Зураг 3.5	Байшинд амьдардаг өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн сууцны халаалтын эх үүсвэр, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	37
Зураг 3.6	Байшинд амьдардаг өндөр настантай өрхийн цахилгааны эх үүсвэр, 2010 он.....	37
Зураг 3.7	Байшинд амьдардаг өрхийн ундны усны эх үүсвэр, хот, хөдөө, хувиар, 2010 он.....	39
Зураг 4.1	Өндөр настны хүйсийн харьцаа, үндэс угсаа, хувиар 2000, 2010 он .....	43
Зураг 4.2	Өндөр настны бичиг үсгийн мэдлэг, боловсролын төвшин, хүйс, хувиар, 2010 он.....	48
Зураг 4.3	Өндөр настны бичиг үсгийн мэдлэг, боловсролын төвшин, хот, хөдөө, дунд эзлэх хувиар, 2010 он.....	49
Зураг 4.4	Нийт өндөр настанд ажил эрхэлж байгаа өндөр настны эзлэх хувь, нас, хүйсээр, 2010 он.....	54
Зураг 4.5	Ажил эрхэлдэг өндөр настны боловсролын төвшин, хот, хөдөө, хувиар, 2010 он.....	60
Зураг 4.6	Өндөр настны ажил эрхлэлтийн байдал, хүйсээр, 2010 он .....	62
Зураг 4.7	Хөгжлийн төрөлхийн бэрхшээлтэй өндөр настны хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хүйс, хувиар, 2010 он.....	63

## ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1	Нийт хүн амд өндөр настны эзлэх хувь, аймаг, нийслэлээр, 1989 2000, 2010 он .....	76
Хүснэгт 2.2	Нийт хүн ам, өндөр настны тоо, нийт хүн амд өндөр настны эзлэх хувь, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он .....	76
Хүснэгт 2.3	Өндөр настны тоо, аймаг, нийслэл, насын бүлгээр, 2010 он .....	77
Хүснэгт 2.4	Өндөр настны насын бүтэц, аймаг, нийслэл, хувиар, 2010 он .....	77
Хүснэгт 2.5	Хотын өндөр настны тоо, аймаг, нийслэл, насын бүлгээр, 2010 он .....	78
Хүснэгт 2.6	Хотын өндөр настны насын бүтэц, аймаг, нийслэл, хувиар, 2010 он.....	78
Хүснэгт 2.7	Хөдөөгийн өндөр настны тоо, аймаг, нийслэл, насын бүлгээр, 2010 он .....	79
Хүснэгт 2.8	Хөдөөгийн өндөр настны насын бүтэц, аймаг, нийслэл, хувиар, 2010 он .....	79
Хүснэгт 3.1	Өндөр настны гэр бүлийн байдал, аймаг, нийслэл, хүйс, дунд эзлэх хувиар, 2000, 2010 он .....	80
Хүснэгт 3.2	Өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн тоо, аймаг, нийслэл, хүйсээр, 2000, 2010 он .....	82
Хүснэгт 3.3	Өндөр настан гишүүнтэй өрхийн тоо, аймаг, нийслэл, өрхийн хэлбэр, хувиар, 2000, 2010 он .....	83
Хүснэгт 3.4	Өндөр настан гишүүнтэй өрх, аймаг нийслэл, хот, хөдөө, өрхийн хэлбэр, хувиар, 2010 он .....	84
Хүснэгт 3.5	Өндөр настан тэргүүлэгчтэй байшинд амьдардаг өрхийн халаалтын байдал, аймаг нийслэл, хот хөдөөгөөр, хувиар, 2010 он .....	85
Хүснэгт 3.6	Өндөр настан өрхийн тэргүүлэгчтэй, байшинд амьдардаг өрхийн ундны усны хангамж, эх үүсвэр, аймаг нийслэл, хот хөдөө, хувиар, 2010 он.....	86
Хүснэгт 3.7	Өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн тоо, өрхийн хэлбэр, сууцны өмчийн.....	89
Хүснэгт 3.8	Өндөр настан гишүүнтэй, байшинд амьдардаг өрхийн халаалт,түлшний төрөл байшигийн төрөл, сууцны өмч, эзэмшлийн хэлбэр, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	90
Хүснэгт 3.9.	Өндөр настан гишүүнтэй, байшинд амьдардаг өрхийн ус, цахилгааны хангамж, эх үүсвэр, байшигийн төрөл, сууцны өмч, эзэмшлийн хэлбэр, хот, хөдөөгөөр, 2010 он .....	93
Хүснэгт 3.10	Өндөр настан тэргүүлэгчтэй, өөрийн сууцгүй өрхийн тоо, аймаг нийслэл, хот хөдөө, сууцны өмчийн хэлбэр, өрхийн тэргүүний хүйсээр, хувиар .....	96
Хүснэгт 3.11	Өндөр настан тэргүүлэгчтэй, гэрт амьдардаг өрхийн сууцны нөхцөл, аймаг нийслэл, хот хөдөө, хувиар, 2010 он .....	97
Хүснэгт 3.12.	Өндөр настан тэргүүлэгчтэй, гэрт амьдардаг, ердийн галлагаатай, өрхийн тоо ахуйн нөхцлийн зарим үзүүлэлт, аймаг нийслэл, хот хөдөөгөөр, 2010 он .....	100



Хүснэгт 3.13.	Өндөр настан тэргүүлэгчтэй, гэрт амьдардаг, ердийн галлагаатай өрхийн тоо, ахуйн нөхцлийн зарим үзүүлэлт, аймаг нийслэл, хот хөдөө, хувиар 2010 он .....	101
Хүснэгт 4.1	Өндөр настны тоо, үндэс, угсаа, насны бүлэг, хүйсээр, 2010 он .....	102
Хүснэгт 4.2	Өндөр настны шүтлэгийн байдал, насны бүлэг, шашны төрөл, хот, хөдөөгөөр, 2010 он .....	103
Хүснэгт 4.3.	Өндөр настны боловсрол, бичиг үсгийн мэдлэг, хот хөдөө, аймаг, нийслэлээр, 2010 он .....	104
Хүснэгт 4.4.	Өндөр настан хүн амын тоо, боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр 2010 он .....	107
Хүснэгт 4.5.	Өндөр настны эдийн засгийн идэвх, аймаг, нийслэл, хүйсээр, 2010 он .....	109
Хүснэгт 4.6	Ажил эрхэлдэг өндөр настан, насны бүлэг, хүйс, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	112
Хүснэгт 4.7.	Тэтгвэр авдаг хүн амын тоо, хүйс, боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэгээр, 2010 он .....	112
Хүснэгт 4.8.	Ажил эрхэлдэг өндөр настны тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, насны бүлэг, хүйс, байршилаар, 2010 он .....	113
Хүснэгт 4.9	Ажил эрхэлдэг өндөр настны боловсролын төвшин, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	114
Хүснэгт 4.10	Ажил эрхэлдэг өндөр настан, ажил мэргэжлийн ангилал, хүйс, хот хөдөөгөөр, 2010 он .....	114
Хүснэгт 4.11.	Өндөр настны ажил эрхлэлтийн байдал, насны бүлэг, хот, хөдөөгөөр, 2010 он .....	115
Хүснэгт 4.12.	Хөгжлийн олдмол бэрхшээлтэй суурин хүн амын тоо, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он .....	115

## ӨМНӨХ ҮГ



Улсын Их Хурлаас баталсан Төрөөс хүн амын талаар баримтлах бодлогод “Ахмадууд ажил, амьдралын баялаг туршлага, үндэсний уламжлалаа залуу үеийнхэнд өвлүүлэх, улс орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах, идэвхтэй амьдрах үүсэл санаачлагыг дэмжих, ахмад үеийнхний хөдөлмөр гавьяа зүтгэлийн үнэлгээг оновчтой болгох бодлого баримтлана”<sup>1</sup> дэвшүүлсэн олон зорилтуудыг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах, улмаар тэдгээрийг цаашид боловсронгуй болгон сайжруулахад “Өндөр настан” сэдэвчилсэн судалгаанд тусгагдсан мэдээлэл чухал ач холбогдолтой.

Өндөр настны нийгмийн асуудал, ахуй нөхцөл, аж байдлыг сайжруулах, тэдний эрүүл мэнд, асрамж, сувилгаа, амралтын онцгой нөхцлийг бүрдүүлэх, ажил эрхлэлтийг дэмжих талаар төр засаг, олон нийт, төрийн бус байгууллагын бодлого боловсруулагчид, эрдэмтэн судлаачдад, өндөр настны тоо, нас, хүйсийн бүтэц, байршил, боловсрол, бичиг үсгийн мэдлэг, ажил эрхлэлт, өндөр настны өрх, гэр бүлийн байдал, сууцны нөхцөл, аж байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү сэдэвчилсэн судалгаанд тусгасан нь чухал ач холбогдолтой болсон.

Өндөр настны мэргэжлийн ур чадвар, оюуны чадавх, амьдралын туршлагыг зохистой ашиглан нийгэм, хамт олон, өрх, гэр бүлийн дотор шийдвэр гаргах үйл ажиллагаа, ахмад болон залуу үеийн хоорондын хамтын ажиллагаанд сэдэвчилсэн судалгааны мэдээлэл, санал, дүгнэлт, зөвлөмжүүд чухал ач холбогдолтой болно гэдэгт найдаж байна.

Энэхүү сэдэвчилсэн судалгаа нь Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр гарсан өндөр настанд хамаарах дэлгэрэнгүй мэдээллийг өмнөх тооллогуудын дүнтэй зэрэгцүүлэхийн хамт тэдний хөгжлийн бэрхшээлийн байдал өндөр болон интернет, гар утас хэрэглээний талаарх шинэ мэдээллийг оруулснаар онцлог юм.

УНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА,  
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ ТООЛЛОГЫН  
УЛСЫН КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА


 С.МЭНДСАЙХАН

<sup>1</sup> Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого УБ 2004 он



# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, БУТЭЦ, ОЙЛГОЛТ,  
ТОДОРХОЙЛОЛТ





## 1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Монгол улсын өндөр настны хүн ам зүй, эдийн засгийн идэвх, нийгэм, эдийн засгийн байдал, орон сууцны нөхцөлд сүүлийн 10-20 жилд гарсан өөрчлөлт, нөлөөлсөн нийгэм, эдийн засгийн хүчин зүйлийг улс, аймаг, нийслэлийн хэмжээнд тодорхойлоход энэхүү судалгааны гол зорилго оршино. Энэ үндсэн дээр өндөр настны талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх, цаашид баримтлах бодлогын чанартай санал, зөвлөмж боловсруулахад судалгааны бас нэг зорилго оршино.

Монгол улсын өндөр настны таатай орчинд амьдрах, урт наслах, нийгмийн халамж, үйлчилгээнд хүндрэлгүй хамруулах, ажил эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн бодлогыг боловсруулах үндэслэл, мэдээллийн найдвартай эх үүсвэр бэлтгэхэд зориулж ХАОС-ны 2010 оны улсын тооллогын дунд үндэслэн өндөр настны нийгэм, эдийн засгийн байдлыг илрэхийлсэн нас, хүйсийн бүтэц, гэр бүл, сууцны нөхцөл, ажил эрхлэлт болон боловсролын байдлын талаарх үзүүлэлтийг аль болох өргөн хүрээнд хамруулахыг зорив.

Өндөр настанд “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай” Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэхь хэсэг болон олон улсын нийтлэг жишгийг харгалzan 65, түүнээс дээш настай хүний хамруулах шаардлагатай ч өмнөх тооллогын үр дүнг жишиг, боломжийг алдахгүйн тулд энэхүү тайланд 60, түүнээс дээш насны хүн амыг хамруулав.

Сэдэвчилсэн судалгааны хүрээнд ХАОС-ны 2010 оны тооллогын мэдээлэлд дэлгэрэнгүй шинжилгээ хийж, өмнөх оны тооллогын холбогдох үзүүлэлттэй харьцуулах, өсөлт, бүтцийг тодорхойлох, тухайн үеийн нийгэм, эдийн засгийн бодлого, тэдгээрийн хэрэгжилт, өнөөгийн өндөр настны нийгэм эдийн засгийн байдлыг үндсэн 30 гаруй үзүүлэлтээр тодорхойлов. Мөн өндөр настны талаар төр, засгаас явуулсан бодлогын үр дүн, ялангуяа эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, ахуйн нөхцлийг сайжруулах, урт удаан наслах боломж, нөхцлийг бүрдүүлэхэд зориулсан санал, зөвлөмжийг судалгаанд тусгав.

## 1.2 ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Өндөр настны сэдэвчилсэн судалгаанд Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод ашигласан дараах үндсэн үзүүлэлтийн нийтлэг ойлголт, тодорхойлолтыг хэрэглэсэн болно.

### ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСАН ТООЛЛОГОД ХЭРЭГЛЭСЭН ЗАРИМ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

№	Ойлголт	Тодорхойлолт
<b>ӨРХ, ХҮН АМ</b>		
1.	Өрх	Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангагдаг хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо гэр бүл, ураг төрөл болон хамаатан садны холбоотой хүмүүс, зарим гишүүд нь огт хамааралгүй байж болно.
2.	Үндсэн өрх	“Үндсэн өрх” гэж сууцны төрөл, хэлбэрээс үл хамааран тухайн сууцыг өмчлөгч өрх, сууц эзэмших эрхийн бичиг /ордер/, орон сууц хөлслөх гэрээнд үндсэн дээр эзэмшиж байгаа өрх, өмчлөгч нь өөр этгээд боловч уг сууцанд хамгийн удаан хугацаагаар амьдарч байгаа өрхийг хэлнэ.
3.	Хамт суудаг өрх	Тухайн өрхийн өөрийн сууц биш, тухайн сууц эзэмшигчтэй хамт суудаг өрхийг хамруулна.
4.	Өрхийн тэргүүлэгч	Ам бүлийн гишүүд хэнийгээ өрхийн тэргүүлэгч гэхийг сайн дураар шийдвэрлэнэ. Өрхийн тэргүүлэгч нь өрхдөө байнга оршин суугч, 16-аас дээш настай, өрхийн орлогод голлох хувь нэмэр оруулдаг, өрхийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцдог ам бүлийн аль нэг гишүүн юм.
5.	Өрхийн ам бүлийн гишүүд	Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангагдаг нэг буюу хэсэг хүмүүсийг тухайн өрхийн ам бүлийн гишүүн гэж үзнэ. Гэхдээ тооллогын уед тухайн өрх айлд гишүүдээс нь гадна өрхийн ам бүлд хамаарахгүй садан төрөл, бусад хүмүүс амьдарч болно.

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ, ТҮҮНИЙ ХЭЛБЭРҮҮД

6.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн	Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүн гэнэ.
7.	Төрөлхийн	Удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндэрлээс шалтгаалан бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан.
8.	Олдмол	Ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчиний улмаас бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан.
9.	Харааны	Харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “харах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
10.	Сонсголын	Сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл согог, өвчин эмгэгийн улмаас хүний “сонсох” хэвийн үйл ажиллагааний чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.



11. Хэл ярианы	Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний "ярих" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
12. Хөдөлгөөний	Биеийнхээ тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
13. Сэтгэцийн	Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх, ухамсарлахуйн болон зан төлвийн өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдэцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцооны дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан.

### СУУРЬШИЛ

14. Байнга суудаг	Тооллогын товын байдлаар тухайн засаг захиргааны нэгжид 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин суугаа хүн
15. Түр эзгүй	Тооллогын товоос өмнө үндсэн засаг захиргааныхаа нэгжээс гадагш 6 сар (183 хоног) хүрэхгүй хугацаагаар явсан хүн
16. Түр суугаа	Тооллогын товоос өмнө өөр засаг захиргааны нэгжид 6 сар (183 хоног)-аас доош хугацаагаар сууж байгаа хүн

### БОЛОВСРОЛ

17. Боловсролгүй	ЕБС-ийн 3 дугаар ангийг (1975-1996 он хүртэл), 4 дүгээр ангийг (1975 он хүртэл, 1997-2004 он дуустал), 5 дугаар ангийг (2005 оноос хойш) төгсөөгүй бол <b>Боловсролгүй</b> хүн гэнэ. Мөн 2010 онд ЕБС-ын 1-5 дугаар ангид сурч байгаа, сурч байгаад сургуулиа орхисон хүмүүсийг <b>Боловсролгүй</b> гэж үзнэ.
18. Бага боловсрол	ЕБС-ийн 3 дугаар ангийг (1975-1996 он хүртэл), 4 дүгээр ангийг (1975 он хүртэл, 1997-2004 он дуустал), 5 дугаар ангийг (2005 оноос хойш) төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн хүн
19. Бүрэн бус дунд (суурь) боловсрол	ЕБС-ийн 7 дугаар ангийг (1975 он хүртэл) 8 дугаар ангийг (1975-2004 оныг дуустал) 9 дүгээр ангийг (2005 он ба түүнээс хойш) өдөр, орой эчнээгээр төгссөн, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, суурь боловсролын гэрчилгээтэй хүн
20. Бүрэн дунд боловсрол	ЕБС-ийн 10-р ангийг (2006 он дуустал), 11 дүгээр ангийг (2006 он ба түүнээс хойш) өдөр, орой эчнээгээр төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, бүрэн дунд боловсролын атtestат ба үнэмлэхтэй хүн
21. Техникийн болон мэргэжлийн боловсрол	MCYT (хуучнаар ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүн
22. Тусгай мэргэжлийн дунд боловсрол	Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүн
23. Дээд боловсрол	Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг <b>Дээд боловсролтой</b> гэж үзнэ. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг мөн энэ ангилалд хамааруулна.

24. <b>Бичиг үсэг мэддэг</b>	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) өдөр тутмын амьдралын тухай хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүнийг <b>Бичиг үсэг мэддэг</b> гэж үznэ.
25. <b>Бичиг үсэг мэддэггүй</b>	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаггүй, түүнчлэн унших, бичих чадвараа тодорхой хугацааны дараа алдсан хүнийг <b>Бичиг үсэг мэддэггүй</b> гэж үznэ.

## ГЭРЛЭЛТ, ГЭР БҮЛ

26. <b>Огт гэрлээгүй</b>	Арван тав ба түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүн
27. <b>Батлуулсан</b>	Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүн
28. <b>Батлуулаагүй</b>	Хэдийгээр гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ албан ёсоор батлуулаагүй хүн
29. <b>Цуцалсан</b>	Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацааг харгалзахгүйгээр <b>Цуцалсан</b> гэж үznэ.
30. <b>Тусгаарласан</b>	Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа, дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр <b>Тусгаарласан</b> гэж үznэ.
31. <b>Бэлбэсэн</b>	Эхнэр, нөхрийналь нэгнь насбарснаас хойших хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг <b>Бэлбэсэн</b> гэж үznэ .

## АЖИЛ ЭРХЛЭЛТ

32. <b>Ажил эрхэлдэг хүн</b>	Тооллогын товын үед тогтмол ажил эрхэлж байгаа, эсвэл тогтмол ажил эрхэлдэггүй боловч товын өмнөх 7 хоногт ядаж нэг өдөр цалинтай ажил эрхэлсэн хүн
33. <b>Ажилгүй хүн</b>	Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн эсвэл бүртгүүлээгүй, товын өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй, ажил идэвхтэй хайж байгаа хүн

**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ БА ТОДОРХОЙЛОЛТ!  
ЭДИЙН ЗАСГИЙН БҮХ ТӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛЛЫН  
ТОДОРХОЙЛОЛТ<sup>1</sup>**

## ОРОН СУУЦ

34. <b>Орон сууцны байшин</b>	Бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай, тоолох үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй байгаа сурин барилгын доторх сууцыг хэлнэ. Энэ нь айл, өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрт зориулагдсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, бүрэн тоноглол төхөөрөмж, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна.
35. <b>Бие даасан тохилог сууц</b>	Бие даасан тохилог сууц (хаус) нь нэг өрх амьдрах зориулалттай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний системийн холболт болон оролт нь бие даасан, дулаан агааржуулалтын систем, усан хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай байна.



36. Сууцны тусдаа байшин	Гэр хорооллын хашаанд нэг ба түүнээс олон өрөөтэй, дэд бүтцийн (гал тогоо, онгоц, шүршүүр, халаалтын усан систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг) хангамжууд бүхэлдээ болон аль нэг нь байхгүй сууц орно.
37. Оюутан сурагчдын нийтийн байр	Бүх шатны сургуулиудийн оюутан, сурагчдын хамтран амьдрахад зориулагдсан байр
38. Ажиллагчдын нийтийн байр	Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид нийтээр амьдрахад зориулсан байр
39. Нийтийн зориулалтын бусад байр	Амралтын газар, рашаан сувилал, эмнэлэг, асрамжийн газар, широн, цэргийн хуаран зэрэг хүмүүс бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ суух нийтийн байр
40. Өрөөний тоо	Нийт өрөөний тоонд унтлагын өрөө, амрах болон ажлын өрөө орно.
41. Сууцны талбай (кв.метр)	Сууцны талбайн хэмжээ нь хүн амьдрах талбай /амралтын, унтлагын, хүүхдийн, ажлын болон хооллох өрөө/ туслах өрөө, тасалгаа /гал тогооны, угаалгын, бие засах өрөө, хонгил, ханын шүүгээ, агуулах/-ны талбайн нийлбэр

### 1.3 СУДАЛГААНЫ БҮТЭЦ , АГУУЛГА

Сэдэвчилсэн судалгаа үндсэн дөрвөн бүлэг, дүгнэлт, зөвлөмж, хавсралтаас бүрдэнэ.

Нэгдүгээр бүлэгт судалгааны зорилго, үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт, агуулга, бүтцийг тусгав.

Хоёдугаар бүлэгт өндөр настны тоо, өсөлт, бүтэц бүрэлдэхүүний ерөнхий дүр зураг, насхилтын индекс, хүн ам зүйн ачаалал зэргийг хамруулав.

Гуравдугаар бүлэгт өндөр настны гэр булийн байдал, өрхийн шинж, сууцны төрөл, нөхцөл, цахилгаан, үндны усны хангамж, дулаан, түлшний хэрэглээ, төрөл, цахилгаан эрчим хүчний эх үүсвэр зэрэг ахуйн нөхцөл байдлын үзүүлэлтийг тусгав.


Дөрөвдүгээр бүлэгт өндөр настны нийгэм, эдийн засгийн байдал, үндэс угсаа, бичиг үсгийн мэдлэг, боловсролын төвшин, эдийн засгийн идэвх, ажил эрхлэлт, мэргэжил, боловсролын чадавх, түүнийг хэрхэн ашиглаж байгаа байдал, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй өндөр настан, үүрэн телефон болон интернетийн хэрэглээний ерөнхий дүр зургийг гарган харуулав.

Судалгааны төгсгөлд дүгнэлт, бодлогын зөвлөмжийг оруулав. Мөн өндөр настан судалгааны голлох үзүүлэлтийг хэрэглэгчдэд зориулан аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр боловсруулж хавсаргав.

1 YCX, Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал. УБ, 2011 он

# ХОЁРДУГААР БҮЛЭГ

ӨНДӨР НАСТНЫ ТОО, ӨСӨЛТ, НАС,  
ХҮЙСИЙН БҮТЭЦ





## 2.1 ӨНДӨР НАСТНЫ ТОО, ӨСӨЛТ, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Монгол Улсын хөгжлийн түүхэн хандлагатай уялдаатайгаар хүн амын өсөлт, өндөр настны тоо, насны бүтэц өөрчлөгдсөөр ирэв. Өндөр настны тоо, бүтцийн өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйлийг тодруулахын тулд 1950 он, түүнээс өмнөх үеийн хүн амын төрөлт, өсөлтөд нөлөөлсөн зарим онцлог хүчин зүйлстэй холбон үзэх шаардлага гарч байна.

**ХУСНЭГТ 2.1 ӨНДӨР НАСТНЫ ТОО, ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТ, 1956-2010 ОН**

Он	Хүн ам - бүгд	Үүнээс: Өндөр настны тоо			Нийт хүн амд өндөр настны эзлэх хувь	Жилийн дундаж өсөлт, хувиар	
		60-64	65+	Бүгд		Өндөр настны	Бүх хүн амын
1956	845 481	32 419	52 743	85 162	10.1		
1963	1017 158	35 810	63 988	99 798	9.8	2.29	2.60
1969	1197 595	37 310	71 942	109 252	9.1	1.52	2.76
1979	1595 006	36 659	79 082	115 741	7.3	0.58	2.91
1989	2043 954	36 235	82 628	118 863	5.8	0.27	2.51
2000	2373 493	42 292	82 003	124 295	5.2	0.41	1.40
2010	2754 685	49 453	101 706	151 159	5.5	1.79	1.46

Хүн амын тооны өөрчлөлт нь төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөнөөр тодорхойлогддог. Тооллого хоорондын хүн амын өсөлт нь тухайн үеийн улс төр, нийгэм, хүн ам зүйн хөгжлөөс ихээхэн хамааралтай. 2000-2010 оны хоорондох хугацаанд Монгол Улсын хүн ам 16.1 хувиар өсч, жилийн дундаж өсөлт нь 1.5 хувь байв. Харин өндөр настны тоо 22 хувиар өсч жилийн дундаж өсөлт 1.8 хувь байна. Өсөлтийн энэ төвшин 1989-2000 оны өсөлтөөс 1.4 пунктээр, нийт хүн амын жилийн дундаж өсөлтөөс 0.2 пунктээр өндөр байна. Өндөр настны тоо ингэж өссөн тус улсын хүн амын төрөлт огцом өссөн 1950-иад оны дунд үед шинээр мэндэлсэн иргэд ахмад үеийнхний эгнээд орж байгаатай холбоотой. Хүн амын тоо 1950-иад оны дунд үеэс хурдтай нэмэгдэж, 1989 он хүртэл жилд дунджаар 2.5-аас илүү хувиар өсч байв. Энэ нь ард түмний аж байдал, хүн амын эрүүл мэндийн төвшин дээшилж, төрөлт нэмэгдэхийн зэрэгцээ нас баралт буурч, гадаад шилжих хөдөлгөөн бараг байхгүй байсантай холбоотой байна.

Сүүлчийн 10 жил дараалан нийт хүн амын 5 орчим хувийг өндөр настан эзэлж байна. Нийт хүн амд өндөр настны эзлэх хувь 1956-2000 онд буурч байсан нь төр засгаас хүн амаа өсгөх талаар хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд хүүхэд, залуучуудын тоо эрс нэмэгдэж байсантай холбоотой юм. Өндөр настны тоо 1956-1963 онд 14.6 мянган хүнээр буюу 17.2 хувиар өссөн. Харин 2000-2010 онд 26.9 мянган хүнээр буюу 21.6 хувиар өссөн нь 1956-1963 оныхоос 12 мянган хүнээр нэмэгдсэн байна. Хот, суурин газарт амьдарч байгаа өндөр настны тоо өмнөх 10 жилийнхээс 15.6 пунктээр нэмэгдсэн нь сүүлчийн 10 жилд хүн амын хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнтэй холбоотой.

Сүүлчийн 30 гаруй жилд өндөр настны тоо 35.4 мянган хүнээр өссөний 8.8 хувь нь 1979-1989 онд, 15.3 хувь нь 1989-2000 онд, харин 3/4 хувийг сүүлчийн 10 жилийн өсөлт эзэлж байна.

**ХҮСНЭГТ 2.2 ӨНДӨР НАСТНЫ ТОО, ӨСӨЛТ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР,  
1989, 2000, 2010 ОН**

Насны бүлэг	Өндөр настны тоо			Хүн амын тооны өсөлт			
	1989	2000	2010	хувиар		тоогоор	
				2000/ 1989	2010/ 2000	2000-1989	2010-2000
60-64	36 233	42 292	49 453	116.7	116.9	6 059	7 161
65-69	31 488	35 415	38 232	112.5	108	3 927	2 817
70-74	22 476	20 239	29 332	90.0	144.9	-2 237	9 093
75-79	16 166	14 843	18 617	91.8	125.4	-1 323	3 774
80+	12 498	11 506	15 525	92.1	134.9	-992	4 019
Дун	118 863	124 295	151 159	104.6	121.6	5 432	26 864

Сүүлчийн 30-аад жилийн байдлаар өндөр насны тооны өсөлтийг насны бүлгээр үзэхэд 1989-2000 онд 70-аас дээш насныхын тоо буурсан бол сүүлчийн 10 гаруй жилд өндөр настны тоо насны бүх бүлэгт 8.0-44.9 хувиар өссөн байна.


Манай улсын нийт хүн амын хүйсийн харьцаа (100 эмэгтэйд ногдох эрэгтэй) 2000 оны тооллогын төвшинд хэвээр хадгалагдаж байна. Тус улсад хүйсийн харьцаа 1979 оноос хойш бага зэрэг буурч байгаа нь эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс илүү байдагтай холбоотой.

Хүйсийн харьцаа насны бүлэг ахих тутам мэдэгдэхүйцээр буурч байгаа нь зүй ёсны үзэгдэл. Дэлхийн хүн ам зүйн олон жилийн судалгаанаас үзэхэд төрөх үеийн хүйсийн харьцаа дунджаар 104-106 хооронд байдаг. Монгол Улсад төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа сүүлийн 5 жилд 103-104 байсан байна.

Өндөр настны хүйсийн харьцаа насны бүлэг ахих тутам буурч байгаа нь эмэгтэйчүүд харьцангуй урт насалж байгаатай холбоотой. Үүнийг ахимаг насны бүлэгт, тухайлбал, 70, түүнээс дээш насанд хүйсийн харьцаа 64, 66 болж огцом буурч байгаагаас харж болно. Хүн амын тооны өөрчлөлт нь төрөлт, нас баралт мөн хүн амын шилжих хөдөлгөөнөөс хамааралтай байдаг.

Тухайн улсын хүн амын нас, хүйсийн бүтцийг хүн амын нас, хүйсийн суваргаар тодорхой харуулдаг.

**ЗУРАГ 2.1 ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2000, 2010 ОН**





## Хүмүүнчлэг төр зэрэг, Төрд хүмүүнчлэг зэрэг

Хүн ам, орон сууцны сүүлчийн хоёр тооллогын дунгээр 60, түүнээс дээш насны хүн амын нас, хүйсийн суваргыг зэрэгцүүлвэл нэлээд ялгаатай байна. Тухайлбал, 2000 оны байдлаар 60, түүнээс дээш настай хүн амын тоо 2010 оныхос бага байгаа нь 50-иад жилийн өмнөх хүн амын төрөлт бага, нас барагт, үүний дотор нялхсын эндэгдэл өндөр байсантай холбоотой. Харин 2010 оны тооллогын дунгээр хүн амын нас, хүйсийн суваргын хүрээ өмнөхөөс нэлээд өргөссөн байгаа нь 1955 оноос төрөөс хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар авч хэрэгжүүлсэн бодлогын дунд хүн амын төрөлт нэмэгдсэнийг харуулж байна. Нийт хүн амын дунд өндөр настны эзлэх хувь бага байгаагас суваргын оройн хэсэг буюу 85, түүнээс дээш насныхан зурагт бараг тэмдэглэгдэхгүй ялангуяа эрэгтэйчүүд цөөн байна.

### ХҮСНЭГТ 2.3 ӨНДӨР НАСТНЫ ТОО, НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2000, 2010 ОН

Насны бүлэг	Өндөр настны тоо					
	2000		2010			
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
<b>БҮГД</b>						
60-64	20 778	21 514	42 292	22 106	27 347	49 453
65-69	15 982	19 433	35 415	17 262	20 970	38 232
70-74	8 766	11 473	20 239	13 081	16 251	29 332
75-79	5 832	9 011	14 843	7 252	11 365	18 617
80+	3 634	7 872	11 506	5 112	10 413	15 525
Дүн	54 992	69 303	124 295	64 813	86 346	151 159
<b>ХОТ</b>						
60-64	10 658	11 231	21 889	15 234	19 490	34 724
65-69	8 145	10 335	18 480	11 578	14 426	26 004
70-74	4 579	6 367	10 946	8 594	10 962	19 556
75-79	3 197	4 766	7 963	4 742	7 642	12 384
80+	1 952	4 131	6 083	3 500	6 946	10 446
Дүн	28 531	36 830	65 361	43 648	59 466	103 114
<b>ХӨДӨӨ</b>						
60-64	10 120	10 283	20 403	6 872	7 857	14 729
65-69	7 837	9 098	16 935	5 684	6 544	12 228
70-74	4 187	5 106	9 293	4 487	5 289	9 776
75-79	2 635	4 245	6 880	2 510	3 723	6 233
80+	1 682	3 741	5 423	1 612	3 467	5 079
Дүн	26 461	32 473	58 934	21 165	26 880	48 045

Насны бүлэг	Нийт хүн амд эзлэх хувь					
	2000		2010			
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
<b>БҮГД</b>						
60-64	1.8	1.8	1.8	1.7	2.1	1.9
65-69	1.4	1.6	1.5	1.3	1.6	1.4
70-74	0.7	1.0	0.9	1.0	1.2	1.1
75-79	0.5	0.8	0.6	0.6	0.9	0.7
80+	0.3	0.7	0.5	0.4	0.8	0.6
Дүн	4.7	5.8	5.2	4.9	6.5	5.7
<b>ХОТ</b>						
60-64	1.6	1.6	1.6	1.7	2.1	1.9
65-69	1.2	1.5	1.4	1.3	1.6	1.4
70-74	0.7	0.9	0.8	1.0	1.2	1.1
75-79	0.5	0.7	0.6	0.5	0.8	0.7
80+	0.3	0.6	0.5	0.4	0.8	0.6
Дүн	4.3	5.4	4.9	5.0	6.5	5.8
<b>ХӨДӨӨ</b>						
60-64	1.9	2.0	2.0	1.6	1.9	1.7
65-69	1.5	1.8	1.6	1.3	1.6	1.4
70-74	0.8	1.0	0.9	1.0	1.3	1.2
75-79	0.5	0.8	0.7	0.6	0.9	0.7
80+	0.3	0.7	0.5	0.4	0.8	0.6
Дүн	5.1	6.4	5.7	4.8	6.5	5.7

Сүүлчийн 10 жилд нийт хүн амын тоо 381.2 мянга буюу 16.1 хувиар өссөн байхад өндөр настны тоо 26.4 мянгаар буюу 21.9 хувиар өсч, нийт хүн амын өсөлтөөс 10.3 пунктээр илүү байна. Харин нийт хүн амын жилийн дундаж өсөлт 0.1 пунктээр нэмэгдсэн байхад өндөр настны хүн амын жилийн дундаж өсөлт 1.0 пунктээр нэмэгдсэн байна.

Хүн амын төрөлт 1950-иад оны сүүлчээс 1970-аад оны дунд үе хүртэл эрчимтэй өсч, 1980-1990 онд аажим, харин 1990-1995 онд нэлээд буурч, 2003 оноос төрөлт нэмэгдсэн нь хүн амын өсөлтөд эерэгээр нөлөөлж, нийт хүн амын өсөлтийн хурд тогтворжих, улмаар өндөр настны тоо нэмэгдэх хандлагатай байна.

Өндөр настны тоо, түүний нийт хүн амд эзлэх хувийн жин хот, хөдөөгөөр нэлээд ялгаатай байна. Нийт хүн амд өндөр настны эзлэх хувийн жин 2010 онд 1979 оныхоос 1.8, 1989 оныхоос 0.7 пунктээр буурч, 2000 оныхоос 0.3 пунктээр нэмэгдсэн байна. Хотод байнга оршин суудаг өндөр настны тоо 1979-1989 онд 11.2 мянгаар буюу 24.0 хувь, 1989-2000 онд 7.4 мянгаар буюу 12.7 хувиар, 2000-2010 онд 37.8 мянгаар буюу 57.8 хувиар өссөн байхад энэ үзүүлэлт хөдөөд 1979-1989 онд 8.1 мянгаар буюу 11.7 хувь, 1989-2000 онд 1.9 мянгаар буюу 3.2 хувь, 2000-2010 онд 10.9 мянгаар буюу 18.5 хувиар тус тус буурсан нь үндсэндээ шилжих хөдөлгөөнтэй холбоотой юм.

Хөдөөгийн нийт хүн амд өндөр настны эзлэх хувь 1979 онд 8.9 хувь, 1989 онд 6.9 хувь, 2000 болон 2010 онд тус бүр 5.7 хувь болж, ерөнхийдөө буурсан байна. Энэ үзүүлэлт хотынхоос 1979 онд 3.2, 1989 онд 1.9, 2000 онд 0.8 пунктээр дээгүүр харин 2010 онд 0.1 пунктээр доогуур байна. Өндөр настны тоо, нийт хүн амд эзлэх хувийн жин аймаг, нийслэлд нэлээд ялгаатай байгааг хавсралт 2.1-2.2-оос харж болно.

Нийт хүн амд өндөр настны эзлэх хувь 2000 оны тооллогын дүнгээр Дундговь (7.2 хувь), Өмнөговь (7.1хувь), Хэнтий (6.1 хувь) аймагт бусад аймаг, нийслэлээс харьцангуй өндөр байсан. Энэ хувь, Дархан-Уул, Орхон аймгаас бусад аймаг, нийслэлд тооллогоос тооллогод

тогтмол буурч байсан бол өмнөх тооллогын дүнгээр ялангуяа Орхон (3.8 хувь). Дархан –Уул аймагт (4.4 хувь) өндөр настны эзлэх хувь бусдаас бага байсан байна. Харин 2010 оны тооллогын дүнгээр бүх аймагт нийт хүн амд өндөр настны эзлэх хувь 4.4- 8.6 пунктээр, Улаанбаатар хотод 0.7 пунктээр нэмэгджээ. Ялангуяа Дундговь, Завхан, Булган, Дархан-Уул, Төв, Орхон аймагт 7.2-8.6 пунктээр нэмэгдсэн нь эдгээр аймгийн хүн ам өсөхийн зэрэгцээ бусад аймгаас төв, суурин газар руу шилжих хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж байна. Харин Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Ховд, Хөвсгөл аймагт нийт хүн амд өндөр настны эзлэх хувь улсын дунджаас байнгаас доогуур (2000 онд 5.2, 2010 онд 11.4) байна. (Аймаг, нийслэлийн нийт хүн амд өндөр настны эзлэх хувийн жинг хавсралт 2.1-ээс үзэж болно).


Хотын хүн амд өндөр настны эзлэх хувь улсын дунджаас 14 аймагт өндөр (Хавсралт 2.2) байгаагийн дотор Дундговь, Төв, Булган, Өвөрхангай, Өмнөговь аймагт нэлээд өндөр байна. Хөдөөгийн хүн амд өндөр настны эзлэх хувь Дундговь, Төв, Дархан-Уул, Булган аймагт нэлээд өндөр байгааг эдгээр аймгийн төр, захиргааны байгуулагаас тавих анхаарал, халамж, нийгмийн үйлчилгээг нэмэгдүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй байна.

Монгол Улсын өндөр настны тоо, нийт хүн амд эзлэх хувь 1990-2000 оны хооронд хамгийн бага төвшинд байсан бол 2010 онд өмнөх тооллогоос 2.2 дахин өсч, цаашид нэлээд нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь 1950-иад оны үеэс тус улсын хүн амын төрөлт нэмэгдэж эхэлсэн төдийгүй эдийн засаг, нийгмийн хөгжил хурдасч, эрүүл мэндийн бүх төрлийн үйчилгээ үнэ, төлбөргүй байсантай холбоотой юм. Түүнчлэн 1950-иад оны сүүлчээр хүн амыг эрүүлжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ үүний дотор арьс өнгө, сүрьеэ өвчтэй хүмүүсийг илрүүлэн үнэ төлбөргүй эмчлэн эдгэрүүлэх арга хэмжээ авсан билээ. Манай орны эрүүлийг хамгаалах систем тууштай хөгжихийн хэрээр хүн амын нас баралт, ялангуяа хүүхдийн болон нялхсын эндэгдэл нэлээд буурсан нь төрөлт нэмэгдэж, хүн амын өсөлтийн хурд өндөр байсан үед төрсөн хүмүүс 2000-2010 оны дунд үеэс өндөр насанд шилжих эхэлсэн тул өндөр настны тоо өмнөх үеийнхээсээ өсч цаашид эрс өсөх хандлагатай байна.

Манай улсын хүн амын насны бүтцэд 2000 оноос нэлээд өөрчлөлт гарчээ. Хүн амын насны бүтэц идэршиж, хөдөлмөрийн насны хүн амын тоо хамгийн их байх үе буюу “хүн ам зүйн цонх”-ны үе эхлээд байна. Хүн ам зүйн энэхүү онцлог үе цаашид удаан үргэлжлэхгүй байж ч болох юм. Ийнхүү хүн амын насны бүтэц аажмаар өөрчлөгдж, өндөр настны бүх хүн амд эзлэх хувь нэмэгдэх юм.

Хүн амын төрөлт, өсөлтийн үе үеийн онцлогоос хамаарч хүн амын насны бүтцэд нэлээд өөрчлөлт гарч байсныг дараах зургаас харж болно.

### ЗУРАГ 2.2 НИЙТ ХҮН АМД 0-14, 60, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВИЙН ЖИН



Олон улсын нийтлэг жишгийг харгалзан өндөр настныг 60-64, 65-74, 75-79, 80, түүнээс дээш настай гэж ангилж, насных нь бүтцийг тодорхойлов. Нийт өндөр настны дунд 60-64 насныхан тэтгэвэр тогтоолгон авах эрх нь үүсээд удаагүй, “Төрийн албаны тухай” Монгол Улсын хуулийн дагуу төрийн албан хаагч нь 65 нас хүртэл ажиллах боломжтой зэргийг үндэслэж өндөр настан дундаа харьцангуй “залуу” гэж үзэж болно. Харин 65-74 насны өндөр настан өөрийн боловсрол, мэргэжлийн чадвар, ажлын дадлага, туршилага зэргийг үндэслэн ажиллах, ялангуяа боловсрол, шинжлэх ухаан, удирдлагын салбар болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд оролцох боломжтой “дунд” насныхан болно. Харин 75-аас дээш насныхыг манай орны нөхцөлд ажиллах чадвар нь буурсан, асаргаа сувилгаа, нийгмийн халамжийн үйчилгээг насны өмнөх 2 бүлгийнхнээс илүү шаарддаг зэргийг үндэслэн “ахимаг настан” гэж ангилж судалгаанд тусгав.

#### ХҮСНЭГТ 2.4 ӨНДӨР НАСТНЫ ТОО, ХОТ, ХӨДӨӨ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Байршил	2000							2010								
	Бүгд	Үүнээс: насны бүлгээр			Бүгд	Үүнээс: насны бүлгээр			Бүгд	Үүнээс: насны бүлгээр			Бүгд	Үүнээс: насны бүлгээр		
		60-64	65-74	75+		60-64	65-74	75+		60-64	65-74	75+		60-64	65-74	75+
БҮГД	100.0	34.0	44.8	21.2	100.0	32.7	44.7	22.6								
Хот	100.0	33.5	45	21.5	100.0	33.7	44.2	22.1								
Хөдөө	100.0	34.6	44.5	20.9	100.0	30.7	45.8	23.5								

Өндөр настны насны бүтэц байршил, аймаг, нийслэлээр харилцан адилгүй байна (Хавсралт 2.3-2.7). Хотын өндөр настны дунд 75-79 насныхан Дундговь, Өмнөговь, Төв, Хэнтий, Дорнод, Дорноговь, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Хөвсгөл, Ховд, Говь-Алтай аймагт улсын дунджаас дээгүүр, 80, түүнээс дээш насны хүн ам Дундговь, Төв, Өмнөговь, Дорнод, Сүхбаатар, Өвөрхангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Орхон, Говьсүмбэр, Хөвсгөл, Хэнтий аймагт улсын дунджаас дээгүүр, хөдөөгийн өндөр настны дунд 75-79 насныхан Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Дорнод, Хөвсгөл, Баян-Өлгий, Дорноговь, Хэнтий аймагт, 80, түүнээс дээш насныхан Дундговь, Хэнтий, Өмнөговь, Баян-Өлгий, Сүхбаатар, Хөвсгөл, Дорнод, Булган, Дорноговь аймагт улсын дунджаас тус тус дээгүүр байна. Нийт хүн амд өндөр настны эзлэх хувь өндөр настнуудын дунд 75, түүнээс дээших насныхан говийн болон зүүн бүсийн аймгууд мөн Булган. Хөвсгөл. Орхон аймагт өндөр байна. Хүн амын тоо, бүтэц, байршилд нөлөөлдөг үндсэн үзүүлэлтүүдийн нэг нь шилжих хөдөлгөөн юм.

#### ХҮСНЭГТ 2.5 ӨНДӨР НАСТНЫ ШИЛЖИН СУУРЫШИЛТ

	2000 он							2010 он						
	Бүгд		Хот		Хөдөө			Бүгд		Хот		Хөдөө		
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь												
БҮГД	124 295	100.0	65 361	100.0	58 934	100.0	151 159	100.0	103 114	100.0	48 045	100.0		
Төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд оролцоогүй	69 975	56.3	22 263	34.1	47 712	81.0	53 200	35.2	22 377	21.7	30 823	64.2		
Шилжиж ирсэн	54 320	43.7	43 098	65.9	11 222	19.0	97 959	64.8	80 737	78.3	17 222	35.8		
Үүнээс:														
1 жил хүртэл	2 662	2.1	2 162	3.3	500	0.8	3 501	2.3	2 969	2.9	532	1.1		
1-4 жил	4 301	3.5	3 308	5.1	993	1.7	6 246	4.1	5 166	5.0	1 080	2.2		
5-9 жил	3 545	2.9	2 663	4.1	882	1.5	9 245	6.1	8 415	8.2	830	1.7		
10 + жил	43 812	35.2	34 965	53.5	8 847	15.0	78 967	52.2	64 187	62.2	14 780	30.8		

Хотод байнга оршин суудаг өндөр настны дийлэнх нь шилжин ирсэн байхад хөдөөгийн өндөр настны 81.0 хувь нь уугуул нутагтаа амьдарч байна. Энэ нь хөдөөнөөс хотруу шилжин суурьшигчдын дийлэнх нь залуу, идэр насныхан байж, хөдөөд гол төлөв хөгшчүүл төрсөн газартаа үлдэж байгааг харуулж байна.

#### **ХҮСНЭГТ 2.6 ШИЛЖИН СУУРЬШСАН ӨНДӨР НАСТНЫ ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010 ОН**

Насны бүлэг	2000			2010		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
60-64	35.3	34.1	39.9	34.2	33.5	37.6
65-69	28.3	28.4	27.9	25.8	25.6	27.3
70-74	16.4	16.8	14.9	19.0	19.1	18.4
75-79	11.6	11.8	10.9	11.4	11.8	9.3
80+	8.4	8.9	6.4	9.6	10.0	7.4

#### **2.2 ӨНДӨР НАСТНЫ ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСЖИЛТЫН ИНДЕКС, ГОЛЧ НАС**

Энэ хэсэгт өндөр настны хүн ам зүйн үзүүлэлтийн өөрчлөлтийг тусгав.

Өндөр настны хүйсийн харьцаа. Хүйсийн харьцааг 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоогоор илэрхийлнэ.

Өндөр настны голч нас. Энэ үзүүлэлтээр өндөр настны тоо ямар наснаас хоёр тэнцүү хэсэгт хуваагдаж байгаа буюу насжилт нэмэгдэж байгаа эсэхийг харуулна.

Насжилтын индекс. Энэ үзүүлэлтээр 15 хүртэл настай 100 хүүхдээс дунджаар хэд нь 60, түүнээс илүү наслах боломжтойг илэрхийлнэ.


#### **ХҮСНЭГТ 2.7 ӨНДӨР НАСТНЫ ХҮН АМ ЗҮЙН ҮНДСЭН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 1989, 2000, 2010 ОН**

Үзүүлэлт	1989	2000	2010
Хүйсийн харьцаа	78	79	75
Нийт хүн амд эзлэх хувийн жин	5.8	5.2	5.7
Голч нас	63.7	62.8	62.3
Насжилтын индекс	13.9	14.6	12.2
Жилийн дундаж өсөлт	0.27	0.41	1.8

Монгол Улсын хүн амын хүйсийн харьцаа 1989 онд 99.7, 2000 онд 98.5, 2010 онд 98.1 болж буурах хандлагатай байна. Өндөр настны хувьд хүйсийн харьцаа улсын дунджаас нэлээд доогуур байдаг нь эмэгтэйчүүдийн дундаж нас эрэгтэйчүүдийнхээс ямагт өндөр байдагтай холбоотой. Нас ахих тутам хүйсийн харьцаа буурдгийг дараах зургаас харж болно.

Манай өндөр насны хүн амын голч нас 2010 онд 62.3 байна.

ЗУРАГ 2.3. ӨНДӨР НАСТНЫ ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ БҮЛГЭЭР,  
2000, 2010 ОН



Өндөр насанд шинээр шилжиж байгаа хүний тоо өмнөх 10 жилийнхээс нэмэгдсэнтэй холбоотойгоор өндөр настны голч нас 2000 оноос эхлэн бага зэрэг буурч байна. 1979-1989 онд 60-64 насныхан 424 хүнээр буурч байсан бол 1989-2000 онд энэ үзүүлэлт 6057 хүнээр, сүүлийн 10 гаруй жилд 7161 хүнээр нэмэгдэж, харин насжилтын индекс 2000 онд 1989 оныхоос 0.7 пунктээр, 2010 онд өмнөх 10 жилийнхээс 2.4 пунктээр буурсан байна.

### 2.3 ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ, ТҮҮНИЙ ЧИГ ХАНДЛАГА

Хүн амын насны бутцийн өөрчлөлтийг илэрхийлэх гол үзүүлэлтийн нэг нь хүн ам зүйн ачаалал билээ. Хүн ам зүйн ачаалал нь хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгчийг тодорхойлдог. Хөдөлмөрийн насны (15-59 насны) буюу тэжээгч, тэжээлгэгчийн (0-14 настай хүүхэд, 60, түүнээс дээш насныхан) харьцааг тодорхойлж байгаагаараа энэ үзүүлэлт эдийн засгийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйлийн нөлөөг илэрхийлдэг ач холбогдолтой.

ХҮСНЭГТ 2.8 ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ, 2000, 2010 ОН


Хүн ам зүйн ачаалал	2000	2010
БҮГД	69.5	48.8
0-14 насаар	60.6	40.6
60+ насаар	8.9	8.2

Хүн ам зүйн ачаалал 2010 онд 2000 оныхоос 20.7 пунктээр буурсан нь хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгчийн тоо сүүлчийн 10 жилд 20 хүнээр буурсантай холбоотой бөгөөд энэ нь хүүхдийн ачаалал мөн 20-иор буурснаас шалтгаалсан. Харин өндөр настны хувьд өөрчлөлт гараагүй байна. Сүүлийн жилүүдэд төрөлт багассан ч өндөр настны хүн амын тоо нэмэгдсэнээс хүн ам зүйн ачаалалд үзүүлэх нөлөөлөл ойролцоо байна.



# ГУРАВДУГААР БҮЛЭГ

Өндөр настны гэр бүлийн байдал,  
сууцны нөхцөл



### 3.1 ӨНДӨР НАСТНЫ ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ


Өндөр настны гэр бүлийн байдал нь нийт хүн амын болон залуучуудын гэр бүлийн байдлаас нэлээд ялгаатай. Огт гэр бүл болоогүй хүний эзлэх хувь бага, бэлбэсэн хүний эзлэх хувь нэлээд өндөр байдаг онцлогтой. Хүн амын насны бүлэг ахих тутам өндөр насны бэлбэсэн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс олон байна. Энэ нь эмэгтэйчүүдийн дундаж нас эрэгтэйчүүдээс өндөр байдагтай холбоотой. Үүнтэй уялдан өндөр настны дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь илүү, хүйсийн харьцаа бага байдгийг өмнө дурьдсан билээ.

**ХҮСНЭГТ 3.1 НИЙТ ХҮН АМЫН БОЛОН ӨНДӨР НАСТНЫ ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ,  
ХҮЙС, ХУВИАР, 2000, 2010 ОН**

Гэр, бүлийн байдал	2000				2010			
	Нийт хүн ам		Өндөр настан		Нийт хүн ам		Өндөр настан	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Огт гэр бүл бoloогүй	36.6	29.8	2.8	3.1	34.4	28.2	2.4	2.9
Гэр бүлтэй, хамтран амьдрагч	58.5	57.1	70.8	33.8	60.7	59.6	76.4	43.9
Цуцалсан, тусгаарласан	2.1	3.3	2.0	1.0	2.7	3.5	2.0	1.6
Бэлбэсэн	2.8	9.8	24.4	62.1	2.2	8.7	19.2	51.6

Өндөр настны гэр бүлийн байдлыг аймаг, нийслэлээр хавсралт 3.1-ээс үзэж болно.

**ЗУРАГ 3.1 НИЙТ ӨНДӨР НАСТАНД БЭЛБЭСЭН ӨНДӨР НАСТНЫ ЭЗЛЭХ ХУВЬ,  
НАС, ХҮЙСЭЭР, 2000, 2010 ОН**



Өндөр настны гэр бүлийн байдлыг насны бүлэг, хүйсээр ангилан үзвэл зарим үзүүлэлт ялгаатай байна (Хүснэгт 3.2).

Өндөр настны дунд гэр бүлтэй эрэгтэйчүүдийн эзлэх хувь насны бүх бүлэгт эмэгтэйчүүдийнхээс бараг 1.7 дахин их байхад, бэлбэсэн эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс 2.7 дахин их байна. Гэхдээ 2000 онтой харьцуулахад бэлбэсэн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн

тухайн насны бүлэгт эзлэх хувь насны аль ч бүлэгт буурсан байна. Энэ нь өндөр настан эрт бэлбэсэрдэг тохиолдол буурч байгааг харуулж байна. Гэр бүлтэй өндөр настан эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тухайн насны бүлэгт эзлэх хувь 60-64 насных 2.5-9.0, 65-69 насных 0.4-10.0, 70-74 насных 8.0-13.0, 75-79 насных 7.2-12.5, 80, түүнээс дээш насных 12 пунктээр нэмэгдсэн нь өндөр настны насжилт нэмэгдэж байгааг харуулж байна. Харин өрх толгойлсон эмэгтэйчүүд нэмэгдсэн нь эмэгтэйчүүд дахин гэрлэх магадлал эрэгтэйчүүдээс бага байж, өрх толгойлох болсонтой холбоотой.

### ХҮСНЭГТ 3.2 ӨНДӨР НАСТНЫ ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Гэр, бүлийн байдал	Насны бүлэг, хүйсээр								
	60-64			65-69			70-74		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Огт гэр бүл боловгуй	2.3	2.9	2.6	2.5	3.0	2.8	2.5	3.0	2.8
Батлуулсан гэр бүлтэй	80.0	55.5	66.4	75.4	46.3	59.5	69.5	36.1	51.0
Батлуулаагүй гэр бүлтэй	5.0	3.0	3.9	4.4	2.4	3.3	3.5	2.3	2.8
Тусгаарласан	1.1	1.0	1.0	0.8	0.7	0.8	0.8	0.6	0.7
Цуцалсан	1.6	1.5	1.5	1.1	1.0	1.0	0.8	0.6	0.7
Бэлбэсэн	10.0	36.1	24.6	15.8	46.6	32.6	22.9	57.4	42.0
<b>ХҮНИЙ ТОО</b>	<b>22 106</b>	<b>27 347</b>	<b>49 453</b>	<b>17 262</b>	<b>20 970</b>	<b>38 232</b>	<b>13 081</b>	<b>16 251</b>	<b>29 332</b>

Гэр, бүлийн байдал	Насны бүлэг, хүйсээр								
	75-79			80+			Бүгд		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Огт гэр бүл боловгуй	2.7	2.8	2.8	1.8	2.6	2.3	2.4	2.9	2.7
Батлуулсан гэр бүлтэй	61.0	27.4	40.5	50.2	18.2	28.7	72.2	41.4	54.6
Батлуулаагүй гэр бүлтэй	3.4	2.1	2.6	3.1	2.4	2.7	4.2	2.5	3.2
Тусгаарласан	0.8	0.5	0.6	0.7	0.4	0.5	0.9	0.7	0.8
Цуцалсан	0.6	0.5	0.5	0.3	0.3	0.3	1.1	0.9	1.0
Бэлбэсэн	31.5	66.7	53.0	43.9	76.1	65.5	19.2	51.6	37.7
<b>ХҮНИЙ ТОО</b>	<b>7 252</b>	<b>11 365</b>	<b>18 617</b>	<b>5 112</b>	<b>10 413</b>	<b>15 525</b>	<b>64 813</b>	<b>86 346</b>	<b>151 159</b>

## ХОТ

Гэр, бүлийн байдал	Насны бүлэг, хүйсээр								
	60-64			65-69			70-74		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Огт гэр бүл болоогүй	1.9	1.9	1.9	2.2	1.7	1.9	1.9	1.7	1.7
Батлуулсан гэр бүлтэй	80.0	56.5	66.8	75.7	48.8	60.8	70.8	39.3	53.1
Батлуулаагүй гэр бүлтэй	5.5	3.4	4.3	4.8	2.7	3.6	3.8	2.4	3.0
Тусгаарласан	1.2	1.1	1.2	0.9	0.8	0.8	0.8	0.5	0.7
Цуцалсан	1.9	1.8	1.8	1.1	1.2	1.2	1.0	0.6	0.8
Бэлбэсэн	9.5	35.3	24.0	15.3	44.8	31.7	21.7	55.5	40.7
<b>ХҮНИЙ ТОО</b>	<b>15 234</b>	<b>19 490</b>	<b>34 724</b>	<b>11 578</b>	<b>14 426</b>	<b>26 004</b>	<b>8 594</b>	<b>10 962</b>	<b>19 556</b>

Гэр, бүлийн байдал	Насны бүлэг, хүйсээр								
	75-79			80+			Бүгд		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Огт гэр бүл болоогүй	2.1	1.5	1.7	1.5	1.5	1.5	2.0	1.7	1.8
Батлуулсан гэр бүлтэй	63.8	30.7	43.4	52.4	20.9	31.5	73.1	44.0	56.3
Батлуулаагүй гэр бүлтэй	3.7	2.3	2.8	3.4	2.6	2.9	4.6	2.8	3.6
Тусгаарласан	0.8	0.5	0.6	0.6	0.4	0.5	0.9	0.8	0.9
Цуцалсан	0.7	0.5	0.6	0.3	0.3	0.3	1.3	1.1	1.2
Бэлбэсэн	28.9	65.5	50.9	41.8	74.3	63.3	18.1	49.6	36.2
<b>ХҮНИЙ ТОО</b>	<b>4 742</b>	<b>7 642</b>	<b>12 384</b>	<b>3 500</b>	<b>6 946</b>	<b>10 446</b>	<b>43 648</b>	<b>59 466</b>	<b>103 114</b>

## ХӨДӨӨ

Гэр, бүлийн байдал	Насны бүлэг, хүйсээр								
	60-64			65-69			70-74		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Огт гэр бүл болоогүй	3.1	5.4	4.3	3.3	6.0	4.7	3.7	5.9	4.9
Батлуулсан гэр бүлтэй	79.9	53.1	65.6	74.7	40.9	56.6	67.1	29.5	46.8
Батлуулаагүй гэр бүлтэй	3.9	2.0	2.9	3.4	1.8	2.6	2.9	2.0	2.4
Тусгаарласан	1.0	0.6	0.8	0.6	0.5	0.6	0.9	0.6	0.7
Цуцалсан	0.9	0.7	0.8	1.0	0.6	0.8	0.6	0.6	0.6
Бэлбэсэн	11.2	38.2	25.6	17.0	50.2	34.7	24.8	61.4	44.6
<b>ХҮНИЙ ТОО</b>	<b>6 872</b>	<b>7 857</b>	<b>14 729</b>	<b>5 684</b>	<b>6 544</b>	<b>12 228</b>	<b>4 487</b>	<b>5 289</b>	<b>9 776</b>

Гэр, булийн байдал	Насны бүлэг, хүйсээр									
	75-79					80+			Бүгд	
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Бүгд
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Огт гэр бүл болоогүй	3.8	5.5	4.8	2.3	4.7	3.9	3.3	5.6	4.6	
Батлуулсан гэр бүлтэй	55.6	20.7	34.7	45.6	12.6	23.1	70.3	35.8	51.0	
Батлуулаагүй гэр бүлтэй	2.9	1.6	2.1	2.5	2.0	2.2	3.3	1.9	2.5	
Тусгаарласан	0.7	0.3	0.5	1.0	0.3	0.6	0.8	0.5	0.7	
Цуцалсан	0.5	0.3	0.4	0.3	0.3	0.2	0.8	0.5	0.6	
Бэлбэсэн	36.5	71.6	57.5	48.3	80.1	70.0	21.5	55.7	40.6	
<b>ХҮНИЙ ТОО</b>	<b>2 510</b>	<b>3 723</b>	<b>6 233</b>	<b>1 608</b>	<b>3 467</b>	<b>5 075</b>	<b>21 161</b>	<b>26 880</b>	<b>48 041</b>	

Ялангуяа 65, түүнээс дээш насанд бэлбэсэн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 24 мянгаар илүү байна. Энэ байдал 2000 оны тооллогын үр дүнгээс ч харагдаж байсан.

Өндөр настны гэр булийн ерөнхий төлөв байдал тэдний байнга оршин суудаг газар (хот, хөдөөгөөр) онцын ялгаа байхгүй байна.

### 3.2 ӨНДӨР НАСТНЫ ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХАМААРАЛ, ӨНДӨР НАСТНЫ ӨРХ


Судалгааны энэ хэсэг нь өндөр настны өрхийн тэргүүлэгчийн хамаарал, өндөр настны өрх гэсэн хэсгүүдээс бүрэлдэж байна.

**3.2.1 Өндөр настны өрхийн тэргүүлэгчийн хамаарал.** Өндөр настан өөрөө өрхийн тэргүүлэгч, өрхийн тэргүүлэгч биш бол өндөр настны эхнэр/ нөхөр, эсвэл өндөр настантай өрхийг харуулав. Энэ нь өндөр настны хүн ам зүйн төдийгүй тэдний нийгэм, өрх, гэр бүлдээ гүйцэтгэх үүрэг, хариуцлага, амьдралын хэв маягийг илэрхийлнэ.

Өрхийн тэргүүлэгчийн хамаарал насны бүлэг, хүйсээр нэлээд ялгаатай байгааг хүснэгт 3.3- аас харж болно. Нийт өндөр настны 64.0 хувь буюу 96 мянга нь өрхийн тэргүүлэгч байгаагийн дунд эрэгтэйчүүдийн 90.2 хувь өрхийн тэргүүн байгаа нь Монголын уламжлалт заншил хэвээр хадгалагдаж байгааг харуулж байна.

Өндөр настны өрхийн тэргүүний 60.5 хувийг эрэгтэйчүүд, 39.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж, эрэгтэй тэргүүлэгчтэй өрх 1.5 дахин их байгаа нь гэр булийн нөхөр нь амьд сэргүүн байгаа тохиолдолд эрэгтэй нь өрхөө тэргүүлдэг Монголын уламжлалт заншилтай холбоотой. Өрхийн тэргүүн 6955 эрэгтэй, 14631 эмэгтэй ганц биеэр амьдарч байна. Ганц биеэр амьдарч байгаа өрхийн тэргүүн эрэгтэй, эмэгтэйчүүд өмнөх тооллогоос хойших хугацаанд 1.7 дахин нэмэгдсэн нь анхаарал татах асуудал болж байна. Энэ нь ахмадуудын оршин сууж байгаа орон нутгийн төр, захиргааны байгууллагаас тэдний нийгмийн асуудалд илүү анхаарах шаардлагатайг харуулж байна. Өрхийн тэргүүлэгчийн байдлыг насны бүлгээр ангилж үзвэл насны бүлэг ахих тутам өндөр настан тэргүүнтэй өрх цөөрч хүү, охиньдоо амьдардаг өндөр настны эзлэх хувь нэмэгдэж байна.

**ЗУРАГ 3.2 ӨНДӨР НАСТНЫ ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХАМААРАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН**



**3.2.2 Өндөр настан тэргүүлэгчтэй өрх.** Өрхийн тэргүүлэгч нь 60, түүнээс дээш настай өрхийг өндөр настын өрх гэж үзэв. Өрхийн талаарх ойлголт, тодорхойлолтыг судалгааны нэгдүгээр бүлгээс үзнэ үү.

**ХҮСНЭГТ 3.3 ӨНДӨР НАСТНЫ ӨРХ, ӨРХӨД ТООЛОГДСОН ХҮНИЙ ТОО,**  
**ӨРХИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010 ОН**


Өрхөд тоологдсон хүний тоо	2000						2010					
	Өрхийн тэргүүлэгч нь 60, түүнээс дээш настай өрх	Үүнээс : өрхийн хэлбэрээр					Өрхийн тэргүүлэгч нь 60, түүнээс дээш настай өрх	Үүнээс : өрхийн хэлбэрээр				
		Ганц бие	Ам бүлээрээ байгаа	Нийлмэл ам бүлтэй	Холимог ам бүлтэй	Ганц бие	Ам бүлээрээ байгаа	Нийлмэл ам бүлтэй	Холимог ам бүлтэй			
<b>БҮГД</b>	100.0	16.9	39.5	41.6	2.0	100.0	10.6	62.4	24.9	2.1		
1	100.0	100.0				100.0	100.0					
2	100.0		76.0	22.6	1.4	100.0		80.2	18.1	1.6		
3-4	100.0		48.9	48.8	2.2	100.0		77.3	20.9	1.8		
5-6	100.0		29.5	67.7	2.7	100.0		53.3	43.3	3.5		
7+	100.0		14.7	80.8	4.5	100.0		23.8	70.3	5.8		
<b>ХОТ</b>	<b>100.0</b>	<b>11.8</b>	<b>33.2</b>	<b>52.3</b>	<b>2.7</b>	<b>100.0</b>	<b>9.9</b>	<b>57.5</b>	<b>30.3</b>	<b>2.4</b>		
1	100.0	100.0				100.0	100.0					
2	100.0		76.5	21.9	1.6	100.0		77.9	20.3	1.8		
3-4	100.0		41.4	56.0	2.6	100.0		73.0	25.0	2.0		
5-6	100.0		18.6	78.0	3.4	100.0		41.9	54.1	3.9		
7+	100.0		7.0	87.5	5.5	100.0		13.2	80.2	6.5		
<b>ХӨДӨӨ</b>	<b>100.0</b>	<b>21.9</b>	<b>45.5</b>	<b>31.3</b>	<b>1.3</b>	<b>100.0</b>	<b>12.2</b>	<b>72.3</b>	<b>13.9</b>	<b>1.5</b>		
1	100.0	100.0				100.0	100.0					
2	100.0		75.6	23.2	1.2	100.0		84.9	13.7	1.3		
3-4	100.0		56.1	41.9	1.9	100.0		86.4	12.3	1.3		
5-6	100.0		44.7	53.6	1.8	100.0		75.7	21.8	2.6		
7+	100.0		33.0	64.9	2.1	100.0		56.3	40.0	3.7		

Өндөр настны нэг өрхөд дунджаар 3.4 хүн тоологдсон нь улсын дунджаас 0.5 хүнээр цөөн байна. Үүнийг өндөр настны хүүхдүүд нь өрх тусгаарласантай холбон тайлбарлаж болох юм. Хотод байнга оршин суудаг өндөр настны өрхөд дунджаар 3.5 хүн, хөдөөд З хүн тоологдсон нь нэг талаар шилжих хөдөлгөөнтэй холбоотой байхын зэрэгцээ хот, суурин газрын өрхийн хувьд хөдөөнөөс ирсэн оюутан, сургчид болон хамаатан садан нь түр амьдарч байж болно. Мөн сууцны хүрэлцээ, хангамжаас шалтгаалан садан төрлөөрөө, танилаараа хэд хэдэн гэр бүл нэг өрх болон хамт амьдрах тохиолдол хот, суурин газарт түгээмэл байгаатай холбоотой.

Манай улсад ам бүлээрээ эсвэл садан төрлөөрөө хамтран нэг өрх болон амьдардаг уламжлалт хэв шинж хэвээр хадгалагдаж байгааг улсын хэмжээний болон өндөр настны өрхүүдийг өрхийн хэлбэрээр ангилсан үзүүлэлтээс харж болно.

Ам бүлээрээ амьдарч байгаа өрх өндөр настны өрхийн 62.4 хувийг, нийлмэл өрх 24.9 хувийг эзлэж байгаа нь өндөр настнууд үр хүүхэд, садан төрөлтэйгээ хамтран амьдрах тохиолдол илүү байгааг харуулж байна. Энэ нь өндөр настны өөрийнх нь амьдрал ахуйд нь тус дэмтэй байдагтай холбоотой байж болох юм. Хөдөөгийн өрхийн дунд ам бүлээрээ өрх хотынхоос 14.8 пунктээр илүү байгаа нь тэнд сууцны хангамж хот, суурин газраас сайн, иргэд өөрсдөө монголын уламжлалт сууц болох гэр болон зарим нутагт байшин барьж амьдрах нөхцөл боломж илүү байдагтай холбоотой.

### ЗУРАГ 3.3 ӨНДӨР НАСТНЫ ӨРХ, ӨРХӨД ТООЛЛОГДСОН ХУНИЙ ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН




### 3.3 ӨНДӨР НАСТНЫ СУУЦНЫ ТӨРӨЛ, НӨХЦӨЛ

Хүний амьдралын анхдагч хэрэгцээ, байгаль, цаг уурын аливаа үзэгдэл, гадны нөлөө, бусдаас тусгаарлан эрүүл, тав тухтай, аюулгүй амьдрах үндсэн орчин бол сууц юм. Сууцны нөхцөл, дэд бүтцийн хангамж нь хүн амын амьжиргааны төвшин, амьдралын чанарыг үнэлэх боломжтой. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор өрхийн амьдарч байгаа сууцыг өөрийн орны онцлогтой уялдуулан байшин гэр гэж үндсэнд нь хоёр төрөл болгож, тооллогын хуудсанд тус тусад нь хариулт авахаар тусгасан. Энэ нь тэдгээр сууцны хийц, бүтэц, ахуй нөхцлийн үзүүлэлт ялгаатай байдагтай холбоотой юм. Сууцтай холбогдох ойлголт, тодорхойлолтыг судалгааны 1 дүгээр бүлгийн ойлголт, тодорхойлолт гэсэн хэсгээс үзнэ үү.

Өндөр настны нийт өрхийн 6.7 хувь буюу 6403 өрх, үүнээс хотод 5008 өрх, хөдөөд 1459 өрх өөрийн гэсэн сууцгүй учраас бусадтай хамтран амьдарч байна. Энэ нь үр хүүхэд, бусад хамаатан садантайгаа хамтран нэг өрх болж байгаа дээрх өндөр настнаас ялгаатай бөгөөд тэдгээр нь өндөр настны бие даасан тусгай өрх гэдгийг ойлгох нь чухал.

Хот, хөдөөд амьдарч байгаа өндөр настны өрхийн сууцны төрөл нилээд ялгаатай байна. Өндөр настны нийт өрхийн 61.9 хувь нь байшинд, 38.1 хувь нь гэрт амьдарч байна. Хот, хөдөөд байшинд амьдардаг өндөр настны тоо өсч байгаа нь тохилог сууцад суугчдын тоо нэмэгдэхийн зэрэгцээ иргэд өөрсдөө байшин барьж, амьдрах бололцоо нэмэгдсэн явдал юм.

### ЗУРАГ 3.4 БАЙШИНД АМЬДАРДАГ, ӨНДӨР НАСТАН ТЭРГҮҮЛЭГЧТЭЙ ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР 2010 ОН



Энэ удаагийн тооллогоор сууцны талаарх мэдээллийг байшингийн төрөл, сууцны өмч, эзэмшилийн хэлбэрээр нарийвчлан ангилж авсан нь хүн амын сууцны хангамж, амьжиргааг бодитой үнэлэх боломж олгож байна. Түүнчлэн өрхийн халаалт, ундны усны хангамж зэрэг дэд бүтцийг тодорхойлох үндсэн үзүүлэлтийг ч нарийвчлан тодорхойлсон нь өмнөх тооллогын дүнтэй шууд харьцуулах боломжгүй ч тодорхой хүрээнд үнэлгээг хийж болох юм.

### ХҮСНЭГТ 3.4 БАЙШИНД АМЬДАРДАГ, ӨНДӨР НАСТАНТАЙ ӨРХИЙН ТОО БАЙШИНГИЙН ТӨРӨЛ, ӨМЧ, ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР 2010 ОН

Сууцны төрөл, хэлбэр, зориулалт	Бүгд		Хот		Хөдөө		
	Өрхийн тоо	Хувь	Өрхийн тоо	Хувь	Өрхийн тоо	Хувь	
<b>БҮГД</b>	<b>72 604</b>	<b>100.0</b>	<b>61 250</b>	<b>100.0</b>	<b>11 354</b>	<b>100.0</b>	
Орон сууцны байшин	31 104	42.8	30 690	50.1	414	3.6	
Бие даасан тохилог сууц	771	1.1	765	1.2	6	0.1	
Байшингийн төрөл	Сууцны тусдаа байшин	39 384	54.2	28 700	46.9	10 684	94.1
Оюутан, сурагчдын нийтийн байр	80	0.1	71	0.1	9	0.1	
Ажиллагчдын нийтийн байр	906	1.2	725	1.2	181	1.6	
Нийтийн зориулалтын бусад байр	359	0.5	299	0.5	60	0.5	
Сууцны өмчийн хэлбэр	Төрийн өмчийн ААНБ-ын Иргэний	798 948 70 858	1.1 1.3 97.6	623 788 59 839	1.0 1.3 97.7	175 160 11 019	1.5 1.4 97.0
Сууцны эзэмшилийн хэлбэр	Өөрийн эзэмшилийн Бусдын сууцанд түрээстэй суудаг Бусдын сууцанд түрээсгүй суудаг Бусад	66 192 2 811 3 225 376	91.2 3.9 4.4 0.5	55 826 2 613 2 518 293	91.1 4.3 4.1 0.5	10 366 198 707 83	91.3 1.7 6.2 0.7

Өндөр настны амьдардаг өрхийн 97.6 хувь нь хувийн өмчийн сууцтай, үлдсэн хэсэг нь төрийн болон холимог өмчийн сууцад, 91.2 хувь нь өөрийн эзэмшлийн сууцад амьдарч байна.

Өндөр настны амьдарч байгаа сууцыг байшингийн төрлөөр авч үзвэл өрхийн 54.2 хувь нь сууцны тусдаа байшинд, 42.8 хувь нь орон сууцны байшинд, 1.1 хувь нь бие даасан тохилог сууцанд, 1.3 хувь нь ажилчдын нийтийн болон оюутны дотуур байранд, 0.5 хувь нь зориулалтын бус сууцад амьдарч байна.

Харин өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн 65.5 хувь хотод, 34.5 хувь хөдөөд амьдарч, 46.7 хувь нь гэрт, 52.6 хувь нь байшин сууцанд 0.7 хувь нь зориулалтын бус сууцанд амьдарч байна.

Өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн 97.5 хувь нь үндсэн өрх байна. Үндсэн өрхийн 46.8 хувь нь гэрт, 65.5 хувь нь хотод амьдарч байна.

Өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн 98.3 хувь нь иргэний өмчийн сууцанд, 92.7 хувь өөрийн эзэмшлийн сууцанд амьдарч байгаа нь бусад улс оронтой харьцуулахад нэлээд давуу талтай байна.

Өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн 2.4 хувь нь бусдын сууцанд түрээс төлж амьдарч байгаа бол 0.7 хувь нь зориулалтын бус сууцанд амьдарч байгаагийн дийлэнх нь хотод байна.

### ХҮСНЭГТ-3.5 БАЙШИНД АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТАН ТЭРГҮҮЛЭГЧТЭЙ ӨРХИЙН ТОО, БАЙШИНГИЙН ТӨРӨЛ, ӨМЧ, ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Байшингийн төрөл, сууцны өмч, эзэмшлийн хэлбэр	Бүгд		Үүнээс:			
	Өрхийн тоо	Хувь	Хот	Хувь	Өрхийн тоо	Хөдөө
<b>БҮГД</b>	<b>50 506</b>	<b>100.0</b>	<b>41 800</b>	<b>100.0</b>	<b>8 706</b>	<b>100.0</b>
Байшингийн төрөл	Орон сууцны байшин	20 724	41.0	20 431	48.9	293
	Бие даасан тохилог сууц	465	0.9	460	1.1	5
	Сууцны тусдаа байшин	28 383	56.2	20 161	48.2	8 222
	Оюутан, сурагчдын нийтийн байр	47	0.1	43	0.1	4
	Ажиллагчдын нийтийн байр	627	1.2	492	1.2	135
Сууцны өмчийн хэлбэр	Нийтийн зориулалтын бусад байр	260	0.5	213	0.5	47
	Төрийн өмчийн ААНБ-ын	518	1.0	399	1.0	119
	Иргэний	648	1.3	517	1.2	131
	Өөрийн эзэмшлийн	49 340	97.7	40 884	97.8	8 456
	Бусдын сууцанд түрээстэй судаг	45 930	90.9	38 044	91.0	7 886
Сууцны эзэмшлийн хэлбэр	Бусдын сууцанд түрээсгүй судаг	1 774	3.5	1 637	3.9	137
	Бусад	2 532	5.0	1 918	4.6	614
		270	0.5	201	0.5	69
						0.8

Өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн 97.7 хувь нь иргэний өмчийн сууцанд, 90.9 хувь нь өөрийн эзэмшлийн сууцанд, 3.5 хувь нь түрээсийн сууцанд амьдарч байна. Өрхийн сууцыг төрлөөр нь ангилж үзвэл байшинд амьдарч байгаа өрхийн 41 хувь орон сууцны байшинд, 56.2 хувь сууцны тусдаа байшинд, 0.9 хувь бие даасан тохилог сууцанд амьдарч, энэ өрхүүдийн 65.5 хувь хотод амьдарч байна.

Өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн сууцны нөхцлийг олон улсын нийтлэг жишиг байдлаар өмнөх тооллогоос арай дэлгэрүүлэн, өндөр настны амьдрах орчин, түүний ахуй нөхцлийг өөрийн орны онцлогийг харгалzan үзүүлэх зорилт тавьсан.


**ХҮСНЭГТ- 3.6 ӨНДӨР НАСТАН ТЭРГҮҮЛЭГЧТЭЙ, БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН  
БАЙШИНГИЙН ТӨРӨЛ, ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР, ХУВИАР, 2010 ОН**

Байшингийн төрөл	Бүгд	Халаалтын эх үүсвэр			
		Төвлөрсөн систем	Нам даралтын зуух	Цахилгаан халаагур	Ердийн галлагаа
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>43.9</b>	<b>3.7</b>	<b>0.4</b>	<b>52.0</b>
Орон сууцны байшин	41.0	100.0	0.0	-	-
Бие даасан тохилог сууц	0.9	87.5	9.5	3.0	-
Сууцны тусдаа байшин	56.2	2.4	6.0	0.7	90.9
Оюутан, сурагчдын нийтийн байр	0.1	57.4	19.1	4.3	19.1
Ажиллагчдын нийтийн байр	1.2	34.6	8.3	0.6	56.5
Нийтийн зориулалтын бусад байр	0.5	40.0	14.2	1.5	44.2
<b>ХОТ</b>	<b>100.0</b>	<b>52.1</b>	<b>4.0</b>	<b>0.4</b>	<b>43.5</b>
Орон сууцны байшин	48.9	100.0	0.0	-	-
Бие даасан тохилог сууц	1.1	87.6	9.3	3.0	-
Сууцны тусдаа байшин	48.2	3.0	7.7	0.8	88.5
Оюутан, сурагчдын нийтийн байр	0.1	58.1	18.6	4.7	18.6
Ажиллагчдын нийтийн байр	1.2	40.4	8.9	0.8	49.8
Нийтийн зориулалтын бусад байр	0.5	46.0	15.5	1.4	37.1
<b>ХӨДӨӨ</b>	<b>100.0</b>	<b>4.5</b>	<b>1.8</b>	<b>0.5</b>	<b>93.2</b>
Орон сууцны байшин	3.4	100.0	-	-	-
Бие даасан тохилог сууц	0.1	80.0	20.0	-	-
Сууцны тусдаа байшин	94.4	0.8	1.8	0.5	96.9
Оюутан, сурагчдын нийтийн байр	0.0	50.0	25.0	-	25.0
Ажиллагчдын нийтийн байр	1.6	13.3	5.9	-	80.7
Нийтийн зориулалтын бусад байр	0.5	12.8	8.5	2.1	76.6

Байшинд амьдардаг өрхийн 43.9 хувь төвлөрсөн халаалтын системд холбогдсон, 52.0 хувь нь ердийн галлагаатай байна. Сүүлийн жилүүдэд халаалтын олон төрлийн хэрэгсэл манай улсад орж ирснээр өрхийн 3.7 хувь нь нам даралтын зуух, 0.4 хувь нь цахилгаан халаагур хэрэглэж байна.

Байшинд амьдардаг өрхийн 41.0 хувийг эзэлж буй орон сууцны байшинд амьдардаг халаалтын төвлөрсөн системд бүрэн холбогдсон байхад, бие даасан тохилог сууцад амьдардаг өрхийн 87.5 хувь, оюутан, сурагчдын дотуур байранд амьдардаг өрхийн 57.4 хувь, ажилчдын нийтийн байранд амьдардаг өрхийн 34.6 хувь нь төвлөрсөн халаалтад холбогдсон байна. Харин сууцны тусдаа байшинтай өрхийн 90.9 хувь нь ердийн галлагаатай байна.


**ЗУРАГ 3.5 БАЙШИНД АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТАН ТЭРГҮҮЛЭГЧТЭЙ ӨРХИЙН СУУЦНЫ  
ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН**



Өрхийн халаалтын төрөл хот, хөдөөд нэлээд ялгаатай байна. Хотын өрхийн 53.4 хувь төвлөрсөн халаалттай, 41.8 хувь ердийн галлагаатай байхад хөдөөний өрхийн дийлэнх /92.6 хувь/ ердийн галлагаатай, 4.4 хувь нам даралтын зуух хэрэглэж байна. Ердийн галлагаатай болон нам даралтын зуух хэрэглэж байгаа өрхөд хүйтний улиралд түлээ, нүүрс ихээхэн хэрэгцээтай байдаг. Байшинд амьдардаг өндөр настан өрхийн халаалтыг аймаг, нийслэлээр хавсралт 3.5-д үзүүлэв.

Хүн амын амьжиргааны төвшинг илэрхийлэх үзүүлэлтийн нэг бол цахилгаан эрчим хүчиний хангамж билээ. Байшинд амьдарч байгаа өндөр настын өрхийн 93.9 хувь, үүнээс хотын өрхийн 98.6 хувь, хөдөөгийн өрхийн 70 шахам хувь цахилгааны төвлөрсөн системд холбогдсон байгаа нь цахилгаан эрчим хүчиний найдвартай эх үүсвэртэй болсоныг харуулж байна. Байшингийн төрөл, сууцны өмч, эзэмшилийн хэлбэрээр бага зэргийн ялгаатай байна.

**ЗУРАГ 3.6 БАЙШИНД АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТАНТАЙ ӨРХИЙН ЦАХИЛГААНЫ  
ЭХ ҮҮСВЭР, 2010 ОН**



Цахилгаанаар хотын өрхүүд үндсэндээ хангагдсан, харин хөдөөгийн байшин сууцанд амьдардаг өрхийн хувьд нэлээд ялгаатай байна. Хөдөөгийн өрхийн 23.8 хувь сэргээгдэх эрчим хүчиний, 5 хувь дизель станц, бага оврын цахилгаан эх үүсвэр хэрэглэж, 2.4 хувь нь цахилгааны эх үүсвэргүй байна.


**ХҮСНЭГТ 3.7. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТАН ТЭРГҮҮЛЭГЧТЭЙ ӨРХИЙН  
УНДНЫ УСНЫ ХАНГАМЖ, УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭР, БАЙШИНГИЙН ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ,  
ХУВИАР, 2010 ОН**

Байшингийн терөл	Бүгд	Төвлөр- сөн систем	Үүнээс: Ундны усны эх үүсвэрээр						
			Төвлөрсөн холбогдсон ус түгээх байр	Хамгаа- лагдсан худаг	Хамгаа- лагдсан булаг, шанд	Цэвэр -шүүлэн савласан ус	Төвлөрсөн холбогдоогүй ус түгээх байр	Зөөв- рийн ус	Гол, мөрөн, нуур, хамгаалаг- даагүй худаг, булаг, шанд
<b>БҮГД</b>	100.0	42.8	11.9	12.5	0.5	0.0	17.0	4.5	10.6
Орон сууцны байшин	41.0	99.9	0.1	-	-	-	0.0	-	-
Бие даасан тохилог сууц	0.9	86.8	-	13.2	-	-	-	-	-
Сууцны тусдаа байшин	56.2	0.9	20.5	21.5	0.8	0.2	29.6	7.7	18.8
Оюутан, сурагчдын нийтийн байр	0.1	55.4	21.2	6.4	-	-	8.5	2.1	6.4
Ажиллагчдын нийтийн байр	1.2	25.2	22.8	22.6	0.2	0.3	17.0	8.1	3.8
Нийтийн зориулалтын бусад байр	0.5	25.0	28.1	14.2	0.7	-	18.4	9.6	3.9
<b>ХОТ</b>	<b>100.0</b>	<b>51.0</b>	<b>14.1</b>	<b>7.5</b>	<b>0.2</b>	<b>0.0</b>	<b>19.8</b>	<b>3.8</b>	<b>3.6</b>
Орон сууцны байшин	48.8	99.9	0.0	0.1	-	-	-	-	-
Бие даасан тохилог сууц	1.1	87.0	12.8	0.2	-	-	-	-	-
Сууцны тусдаа байшин	48.2	1.2	28.1	15.0	0.4	0.0	40.3	7.6	7.4
Оюутан, сурагчдын нийтийн байр	0.1	60.5	23.3	4.6	-	-	9.3	-	2.3
Ажиллагчдын нийтийн байр	1.2	29.9	28.8	13.2	0.2	0.4	19.9	6.0	1.6
Нийтийн зориулалтын бусад байр	0.5	29.1	32.3	5.6	-	-	22.1	9.4	1.4
<b>ХӨДӨӨ</b>	<b>100.0</b>	<b>3.7</b>	<b>1.9</b>	<b>36.7</b>	<b>1.7</b>	<b>-</b>	<b>3.3</b>	<b>8.2</b>	<b>44.5</b>
Орон сууцны байшин	3.4	98.3	-	1.7	-	-	-	-	-
Бие даасан тохилог сууц	0.1	80.0	-	20.0	-	-	-	-	-
Сууцны тусдаа байшин	94.4	0.2	2.0	37.5	1.7	-	3.4	8.3	46.8
Оюутан, сурагчдын нийтийн байр	0.0	-	-	25.0	-	-	-	25.0	50.0
Ажиллагчдын нийтийн байр	1.6	8.9	0.7	57.0	-	-	5.9	15.6	11.9
Нийтийн зориулалтын бусад байр	0.5	6.4	8.5	53.2	4.3	-	2.1	10.6	14.9

**Үндны усны хангамж:** Цэвэр усны хүрэлцээ, хангамж, ялангуяа түүний чанар нь хүний эрүүл мэнд, урт удаан наслахад нөлөөлөх гол үзүүлэлтүүдийн нэг билээ. Өндөр настан тэргүүнтэй өрхийн дийлэнх буюу 95.8 хувь амьдарч байгаа орон сууцны байшин ус түгээх төвлөрсөн системд бүрэн холбогдсон байна.

Иргэний өмчийн болон өөрийн эзэмшлийн сууцны 90.3-96.6 хувь нь төвлөрсөн усан хангамжид холбогдсон байна. Байшинд амьдарч байгаа өрхийн 11.9 хувь төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байрнаас, 4.5 хувь нь зөөврийн ус, 10.6 хувь нь гол, мөрөн, хамгаалагдаагүй худгаас ундны ус хэрэглэж байна.

**ЗУРАГ 3.7 БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ҮНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭР,  
ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН**



Өрхийн ундны усны хангамж хот, хөдөөгөөр нэлээд ялгаатай байна. Байшинд амьдарч байгаа хотын өрхийн усан хангамжийн эх үүсвэр улсын дундажтай төстэй байхад хөдөөгийн 2 өрхийн нэг нь гол мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанднаас, 40 шахам хувь хамгаалагдсан худгаас, 8 орчим хувь зөөврийн уснаас хэрэглээгээ хангаж байна. Өндөр настаны өрхийн дийлэнх нь ялангуяа хөдөө байнга оршин суудаг өрх бараг бүхэлдээ усаа

зөөж хэрэглэж байна. Өндөр настны өрхийн усан хангамжийг аймаг, нийслэлээр хавсралт 3.6-аас үзнэ үү.

Байшинд амьдарч байгаа өрхийн дийлэнх цахилгааны найдвартай эх үүсвэртэй байгаа талаар дээр өгүүлсэн. Өрхүүд хоол, хүнсээ бэлтгэхэд ямар түлш хэрэглэж байгаа нь өрхийн амьжиргаа, байгаль орчны эрүүл ахуйтай холбоотой чухал үзүүлэлт юм. Улсын дунджаар өндөр настны өрх хоол, хүнсээ бэлтгэхэд 2 өрхийн нэг нь цахилгаан, 10 өрхийн нэг нь мод, нөгөө нь шахмал түлш, нүүрс, 5.7 хувь аргал, хөрзөн хэрэглэж байна. Түлшний хэрэглээ, төрөл нь байшин сууцны төрлөөр ялгаатай байна. Ялангуяа сууцны тусдаа байшинд амьдардаг өрхийн 90 шахам хувь цахилгааны төвлөрсөн системд холбогдсон хэдий ч хоол, ундаа бэлтгэхэд 14 хувь нь цахилгаан, 35.4-37.8 хувь нь мод, нүүрс, шахмал түлшийг хэрэглэдэг байна. Оюутан, ажиллагчдын нийтийн байранд амьдардаг өрхийн 56.4 хувь цахилгаан, 16.3 хувь мод, 22.5 хувь нүүрс, шахмал түлш, 3.8 хувь аргал, хөрзөн хэрэглэж байна.

Хоол, хүнсээ бэлтгэхэд хэрэглэж байгаа түлшний байдал хот, хөдөөгөөр нэлээд ялгаатай байна. Хотын өрх цахилгаан болон нүүрс, шахмал түлшийг голдуу хэрэглэдэг бол хөдөөний өрхийн үндсэн түлш нь мод, түлээ, аргал, хөрзөн байна.

## ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Монголын уламжлалт сууц болох гэр нь бүтэц хийц, ахуйн нөхцлийн хувьд үндэсний онцлогтой. Гэрийн талбайн хэмжээ нь түүний ханын тооноос хамаарна. Өрхийн амьжиргааны төвшинг илэрхийлэх үзүүлэлтийн нэг бол гэрийн ханын тоо юм.

### ХҮСНЭГТ 3.8 ГЭРТ АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТНЫ ӨРХИЙН ТОО, ГЭРИЙН ХАНЫН ТООГООР, 2010 ОН

Ханын тоо	Бүгд		Хот		Хөдөө	
	Өрхийн тоо	Дунд эзлэх хувь	Өрхийн тоо	Дунд эзлэх хувь	Өрхийн тоо	Дунд эзлэх хувь
<b>ӨРХИЙН ТОО-БҮГД</b>	<b>44 821</b>	<b>100.0</b>	<b>20 525</b>	<b>100.0</b>	<b>24 296</b>	<b>100.0</b>
5 хүртэл	14 526	32.4	6 793	33.1	7 733	31.8
5 ханатай	22 988	51.3	11 311	55.1	11 677	48.1
6 ханатай	6 507	14.5	2 091	10.2	4 416	18.2
8 ханатай	796	1.8	327	1.6	469	1.9
10 ханатай	4	-	3	-	1	-

Гэрт амьдардаг өрхийн 1/3 нь 5 хүртэлх тооны ханатай, 50-иас илүү хувь нь 5 ханатай гэрт амьдарч байгаа нь хот, хөдөөгийн хувьд онцын ялгаагүй байна. Хөдөөгийн өрхийн 20 шахам хувь нь 6 болон түүнээс олон тооны ханатай гэрт амьдарч байна.

Гэрт амьдардаг өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн ахуйн нөхцлийн аймаг, нийслэлээрх үзүүлэлтүүдийг хавсралт 3.11-3.13-аас үзнэ үү.

Гэрт амьдарч байгаа бүх өрхийн халаалт нь ердийн пийшин, зуух байна.

Хот, суурин газарт байнга оршин суудаг, гэрт амьдарч байгаа өндөр настны өрхийн хүйтний улирлын түлээ, нүүрсний хэрэгцээ шаардлага нь анхаарал татах, шийдвэрлэвэл зохих асуудлын нэг байсаар байна. Гэхдээ төв, суурин газрын айл өрхийн түлээ, нүүрсний асуудлыг шийдвэрлэхдээ байгаль орчинд үзүүлэх хорт нөлөөг аль болох бага байлгах, бүрэн шаталтай, утаагүй зуухаар өндөр настны өрхийг тэргүүн ээлжинд хангах нь тэдний ахуй нөхцлийг сайжруулах, урт удаан наслахад нь тустай болно.

# ДОРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Өндөр настны нийгэм, эдийн засгийн  
үндсэн үзүүлэлт



## 4.1 ӨНДӨР НАСТНЫ ҮНДЭС УГСАА

**4.1.1 Улсын харьяалал.** Монгол улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 99.4 хувь, үүнээс өндөр настны 99.8 хувь Монгол Улсын харьят байна. Монгол улсад б, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байгаа гадаадын харьят, өндөр настны 35.1 хувь буюу Оросын Холбооны Улсын харьят 276 иргэд, 27.1 хувь буюу 213 нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын, 9.2 хувь буюу 73 хүн Өмнөд Солонгос улсын, 7.2 хувь буюу 57 нь АНУ-ын, 6.6 хувь буюу 52 нь Япон улсын харьят иргэн байна.

**4.1.2 Үндэс угсаа.** Энэ удаагийн тооллогоор Монгол Улсад 29 үндэс угсааны төлөөлөл тоологдсон.


Монгол Улсын харьят хүн амын 82.4 хувийг, өндөр настны 80 орчим хувийг Халх угсаатан, 10 орчим хувийг Казах, Дөрвөд, Буриад, Баяд угсаатан эзэлж байна. Өмнөх тооллогын үеийнхээс Халхчуудын эзлэх хувь 0.8 пунктээр, Баяд 0.3 пунктээр өсч, Буриад, Казахуудынх 0.2-0.6 пунктээр тус тус буурсан байна.

### ХҮСНЭГТ 4.1 НИЙТ ХҮН АМ, ӨНДӨР НАСТНЫ УЛСЫН ХАРЬЯАЛАЛ, ҮНДЭС УГСАА, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2000, 2010 ОН

Үндэс, угсаа	2000 он				2010 он			
	Нийт хүн ам	Үүнээс: өндөр настан	Үүнд: Эрэгтэй	Нийт хүн ам	Үүнээс: өндөр настан	Үүнд: Эрэгтэй	Эмэгтэй	
<b>БҮГД</b>	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Монгол улсын харьят	99.7	99.6	99.5	99.6	99.4	99.5	99.3	99.6
Үүнээс:үндэс, угсаа								
Халх	81.5	79.5	78.9	80.0	81.9	80.3	79.7	80.8
Казах	4.3	3.9	4.4	3.4	3.8	3.3	3.7	2.9
Дөрвөд	2.8	2.8	2.7	2.8	2.7	2.8	2.7	2.8
Буриад	1.7	2.7	2.6	2.8	1.7	2.5	2.5	2.5
Баяд	2.1	2.1	2.2	2.0	2.1	2.3	2.3	2.3
Бусад	7.2	8.6	8.7	8.6	7.1	8.9	9.2	8.7
Гадаадын харьят, харьяалалгүй	0.3	0.4	0.5	0.4	0.6	0.5	0.7	0.4

Өндөр настны дунд эмэгтэйчүүдийн дундаж нас өндөр байдгийг судалгааны 2-р бүлэгт тайлбарласан. Энэ хандлага Казахаас бусад угсаатны дунд ижил байна. Казакуудаас бусад угсаатны хүйсийн харьцаа ерөнхийдөө бага байна.

**ЗУРАГ 4.1 ӨНДӨР НАСТНЫ ХҮЙСИЙН ХАРЬЦАА, ҮНДЭС УГСАА,  
ХУВИАР 2000, 2010 ОН**



Өндөр настан Казахуудын хүйсийн харьцаа улсын хэмжээний өндөр настан, бусад үндэс угсаатнаас нэлээд өндөр байгаа нь онцлог юм. Монгол Улсын хүн амын доторх олон хүн амтай хоёр дахь угсаатан нь Казахууд (3.4 хувь) бөгөөд хэл, ардын уламжлалт соёл, зан заншил нь монголын бусад угсаатнаас өвөрмөц ялгаатай.

**ХҮСНЭГТ 4.2 ӨНДӨР НАСТНЫ ҮНДЭС УГСАА, НАС, ХҮЙС,  
ХУВИАР, 2010 ОН**

Үндэс, угсаа	Насны бүлгээр								
	60-64			65-69			70-74		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
БҮГД	34.1	31.7	32.7	26.6	24.3	25.3	20.2	18.8	19.4
Монголын харьяат	34.0	31.7	32.6	26.7	24.3	25.3	20.2	18.8	19.4
Үүнээс: үндэс, угсаагаар									
Халх	34.2	31.9	32.9	26.6	24.3	25.3	20.1	18.8	19.3
Казах	30.0	31.6	30.8	26.1	22.9	24.5	21.7	18.9	20.2
Дөрвөд	36.7	33.0	34.5	27.8	27.2	27.4	20.6	19.7	20.1
Буриад	33.5	30.4	31.7	26.2	22.6	24.1	18.6	16.0	17.1
Баяд	32.8	31.8	32.2	30.4	25.1	27.4	20.6	18.5	19.4
Бусад	32.9	28.9	30.7	26.1	23.8	24.8	21.5	19.8	20.6
Гадаадын харьяат, харьяалалгүй	52.1	31.5	43.8	20.9	23.2	21.8	11.0	24.7	16.6

### Хүснэгт 4.2-ын үргэлжлэл

Үндэс угсаа	Насны бүлгээр								Бүгд					
	75-79				80+				Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо
<b>БҮГД</b>	11.2	13.2	12.3	7.9	12.1	10.3	100.0	64 813	100.0	86 346	100.0	151 159		
Монголын харьяат	11.2	13.2	12.3	7.9	12.1	10.3	100.0	64 355	100.0	86 010	100.0	150 365		
<b>ҮҮНЭЭС: ҮНДЭС УГСААГААР</b>														
Халх	11.2	13.0	12.2	7.9	12.0	10.3	100.0	51 641	100.0	69 760	100.0	121 401		
Казах	12.3	12.2	12.2	10.0	14.4	12.3	100.0	2 383	100.0	2 543	100.0	4 926		
Дөрвөд	9.8	11.8	11.0	5.1	8.3	7.0	100.0	1 736	100.0	2 444	100.0	4 180		
Буриад	12.5	15.9	14.4	9.2	15.1	12.6	100.0	1 593	100.0	2 169	100.0	3 762		
Баяд	10.2	13.0	11.8	6.1	11.6	9.2	100.0	1 495	100.0	1 950	100.0	3 445		
Бусад	11.6	14.6	13.3	7.8	12.9	10.7	100.0	5 507	100.0	7 144	100.0	12 651		
Гадаадын харьяат, харьяалалгүй	10.8	15.8	12.8	5.1	4.8	5.0	100.0	489	100.0	336	100.0	825		

Улсын дунджаар өндөр настны хүн амын 10.3 хувийг 80, түүнээс дээш насныхан эзэлж байхад Буриад, Казахуудынх 12.3-12.6 хувь, Халхчуудынх 10.3 хувь байгаа нь бусадтай харьцуулахад арай илүү урт насалж байгааг харуулна. Өндөр настны нийт эмэгтэйчүүдийн дунд 80, түүнээс дээш настны эмэгтэйчүүдийн эзлэх хувь улсын дунджаар 12.1 хувь байхад Буриад 15.1 хувь, Казах 14.4 хувь, Халх 12.0 хувь байгааг бусадтай харьцуулахад эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдээс урт насалдаг болохыг харуулж байна.

### ХҮСНЭГТ 4.3 ӨНДӨР НАСТНЫ ШҮТЛЭГИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010 ОН

Насны бүлэг	Өндөр настан хүн ам		Шүтдэггүй	Шашинтан					
	Бүгд	Хувь		Будда	Христ	Ислам	Бөө	Бусад	
<b>БҮГД</b>	151 159	100.0	25.3	68.2	1.5	3.2	1.4	0.4	
60-64	49 453	100.0	27.9	65.2	1.9	2.9	1.7	0.4	
65-69	38 232	100.0	27.1	66.4	1.7	2.9	1.4	0.4	
70-74	29 332	100.0	26.3	67.4	1.5	3.3	1.2	0.5	
75-79	18 617	100.0	23.5	70.3	1.3	3.2	1.3	0.4	
80+	15 525	100.0	19.1	74.8	1.0	3.8	1.0	0.4	

Нийт хүн амын 38.6 хувь, өндөр настны 25.3 хувь нь шашин шүтдэггүй байна.

Өндөр настны 68.2 хувь будда, 3.2 хувь ислам, харин бөө, христийн шашинтан тус бүр 1.5 хувь байна. Шашин шүтлэгийг өндөр настны насны бүлгээр авч үзэхэд онцын ялгаа байхгүй байна.

## 4.2 ӨНДӨР НАСТНЫ БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН

Монгол Улс 1924 оноос иргэнээ үнэ, төлбөргүйгээр сурч боловсрохыг үндсэн хуулиараа баталгаажуулсан. Өнөөгийн өндөр настны бичигтэн болох, боловсрол эзэмших бодит боломжийг олгосон юм. Хүн амын бичиг үсэгт тайлагдах, боловсрол эзэмших боломж, нөхцөл нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн үе шатаас хамаарч, харилцан адилгүй байсныг энэ бүлэгт харуулна.

Аль нэг хэлээр (бичгийн төрөл хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг үншиж, ойлгож, бичиж чаддаг хүнийг бичиг үсэг мэддэг гэж үзсэн.

Тооллогын дүнгээр бичиг үсэг мэддэг хүн амыг тодорхойлоходоо ямар нэг төвшний боловсролтой хүн ам, боловсролгүй боловч бичиг үсэг мэддэг хүний нийлбэрээр илэрхийлэв.

Бичиг, үсгийн мэдлэг, боловсролын төвшинг өмнөх тооллогуудын дүнтэй зэрэгцүүлэхийн тулд боловсролын төвшингийн зарим үзүүлэлтийг нэгтгэв.

### ХҮСНЭГТ 4.4 ӨНДӨР НАСТНЫ БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 1989, 2000, 2010 ОН

Бичиг үсгийн мэдлэг, боловсролын төвшин	1989 он		2000 он		2010 он	
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Бичиг үсэг мэддэггүй	9.2	34.6	23.4	3.7	13.7	9.2
Бичиг үсэг мэддэг	33.1	33.1	33.1	12.7	19.7	16.6
Бага	35.0	27.1	30.5	37.2	45.5	41.8
Бүрэн бус дунд <sup>1</sup>	9.1	2.7	5.5	15.6	9.2	12.1
Бүрэн дунд, ТМС <sup>2</sup>	7.2	1.9	4.3	8.0	4.2	5.9
ТМД, бүрэн бус дээд <sup>3</sup>	1.1	0.1	0.6	9.2	4.6	6.6
Дээд	5.8	0.6	2.6	13.6	3.1	7.7

<sup>1</sup> суурь боловсролтой хүн ам

<sup>2</sup> бүрэн дунд, техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн ам

<sup>3</sup> тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн ам

Өнгөрсөн 30 гаруй жилд өндөр настны бичиг, үсгийн мэдлэг, боловсролын төвшинд эрс өөрчлөлт гарч, бичиг үсэг үл мэдэгчдийн эзлэх хувь 2000 онд 1989 оныхос 14.2 пунктээр, 2010 онд 2000 оныхос 5.1 пунктээр буурч, өндөр настны дунд боловсролтой хүн амын эзлэх хувь нэмэгдсэн байна. Сүүлчийн 2 тооллогын дүнгээр нийт өндөр настны дунд бага боловсролтой өндөр настны эзлэх хувь 10 пунктээр буурч, харин мэргэжлийн болон дээд боловсролтой өндөр настных 4-11 пунктээр нэмэгдсэн нь манай улсын боловсролын салбарын хөгжлийн ололт, төр, засгаас хүн амын боловсролыг дээшлүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэхэд онцгой анхаарч байсны үр дүн юм.

Мэргэжлийн боловсон хүчнийг 1950-иад оноос эхлэн хилийн чанадад бэлтгэж, улмаар 1960-аад оноос мэргэжлийн дунд болон дээд боловсролтой боловсон хүчнийг дотооддоо олноор бэлтгэх болсонтой холбоотой их, дээд болон мэргэжлийн дунд шатны сургуульд суралцагчдын тоо нэмэгдэж байсан 1960-1980-аад онд 20-25 орчим настай байсан хүмүүс одоо өндөр настны эгнээг тэлж байгаа нь өндөр настны боловсролын бүтцийг өөрчлөгдөхөд нөлөөлжээ.

Өндөр настны насны бүлэг ахих тутам бичиг үсэг үл мэдэгчид, бага боловсролтой хүний эзлэх хувь багасч, бүрэн бус дундаас дээш боловсролтой өндөр настны эзлэх хувь нэмэгдэж байгааг харуулж байна. Энэ хандлага нь өндөр настны хүйс, байршилаар нэгэн адил байгаа нь хүн амын боловсрол эзэмших дээр дурьсан нөхцөл, байдалтай уялдаатай. Зүй тогтлын энэ хандлага нь өндөр настны хүйс, байршилаар нэгэн адил ажиглагдаж байна.

#### ХҮСНЭГТ 4.5 ӨНДӨР НАСТНЫ БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

##### БҮГД

Бичиг үсгийн мэдлэг, боловсролын төвшин	Насны бүлэг, хүйсээр								
	60-64			65-69			70-74		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Доктор	0.7	1.2	0.3	0.7	1.3	0.2	0.5	0.9	0.1
Магистр	1.5	2.3	0.9	0.9	1.5	0.4	0.4	0.6	0.1
Дипломын болон бакалаврын дээд	19.5	23.3	16.5	18.6	25.1	13.3	13.7	21.1	7.7
Тусгай мэргэжлийн дунд	15.0	12.0	17.4	12.0	10.9	12.9	9.0	9.6	8.6
Техник болон мэргэжлийн	3.0	3.8	2.4	2.2	2.9	1.7	2.0	2.5	1.6
Бүрэн дунд	21.2	21.3	21.1	16.2	16.5	15.9	13.3	13.5	13.1
Суурь	14.0	15.6	12.7	12.2	12.9	11.7	10.9	12.4	9.8
Бага	20.5	17.1	23.2	28.8	23.1	33.4	36.9	29.7	42.8
Бичиг үсэг мэддэг	3.2	2.4	3.7	5.7	4.2	6.8	8.7	6.6	10.4
Бичиг үсэг мэддэггүй	1.5	1.1	1.8	2.8	1.7	3.7	4.6	2.9	5.9

Бичиг үсгийн мэдлэг, боловсролын төвшин	Насны бүлэг, хүйсээр								
	75-79				80+				Бүгд
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Доктор	0.4	0.8	0.1	0.3	0.8	0.1	0.6	1.1	0.2
Магистр	0.2	0.3	0.1	0.1	0.3	0.0	0.8	1.4	0.4
Дипломын болон бакалаврын дээд	10.2	18.7	4.8	7.3	16.5	2.8	15.8	22.3	10.9
Тусгай мэргэжлийн дунд	6.8	7.7	6.2	5.0	7.7	3.7	11.0	10.4	11.5
Техник болон мэргэжлийн	1.5	2.0	1.2	1.1	2.0	0.6	2.2	2.9	1.7
Бүрэн дунд	10.9	12.0	10.3	7.5	9.9	6.3	15.7	16.5	15.1
Суурь	8.8	10.0	8.1	5.8	7.8	4.9	11.5	13.0	10.3
Бага	42.1	34.2	47.1	42.1	36.7	44.8	30.6	24.7	35.1
Бичиг үсэг мэддэг	13.3	11.2	14.6	18.1	13.7	20.3	7.7	5.6	9.2
Бичиг үсэг мэддэггүй	5.9	3.2	7.6	12.6	4.6	16.5	4.1	2.1	5.6

ХОТ

Хүснэгт 4.5-ын үргэлжлэл

Бичиг үсгийн мэдлэг, боловсролын төвшин	Насны бүлэг, хүйсээр								
	60-64			65-69			70-74		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Доктор	1.0	1.7	0.4	1.0	1.9	0.3	0.7	1.4	0.2
Магистр	2.1	3.1	1.3	1.2	2.1	0.5	0.5	1.0	0.2
Дипломын болон бакалаврын дээд	25.0	29.7	21.4	24.6	32.5	18.2	18.7	28.7	10.9
Тусгай мэргэжлийн дунд	16.6	12.7	19.7	14.1	11.8	16.0	11.1	10.8	11.3
Техник болон мэргэжлийн	3.0	3.5	2.6	2.3	2.6	2.1	2.2	2.4	2.0
Бүрэн дунд	25.5	25.2	25.8	20.4	20.1	20.7	17.5	17.1	17.9
Суурь	12.5	13.5	11.8	12.2	12.3	12.1	11.9	12.8	11.2
Бага	12.0	8.9	14.4	19.6	13.9	24.2	29.3	20.5	36.2
Бичиг үсэг мэддэг	1.5	1.1	1.8	3.0	1.9	3.9	5.3	3.6	6.6
Бичиг үсэг мэддэггүй	0.7	0.6	0.8	1.5	0.9	2.0	2.8	1.7	3.6

Бичиг үсгийн мэдлэг, боловсролын төвшин	Насны бүлэг, хүйсээр								
	75-79				80+				Бүгд
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Доктор	0.6	1.3	0.1	0.4	1.2	0.1	0.8	1.6	0.2
Магистр	0.3	0.4	0.1	0.2	0.5	0.0	1.2	1.9	0.6
Дипломын болон бакалаврын дээд	14.2	25.9	6.9	10.4	22.7	4.2	20.9	29.3	14.8
Тусгай мэргэжлийн дунд	8.6	8.9	8.4	6.5	9.1	5.2	12.9	11.4	14.1
Техник болон мэргэжлийн	1.8	2.0	1.6	1.3	2.3	0.9	2.4	2.8	2.0
Бүрэн дунд	14.6	15.5	14.1	10.2	12.7	9.0	19.9	20.2	19.6
Суурь	10.2	11.2	9.5	7.0	8.3	6.3	11.5	12.4	10.8
Бага	37.9	27.3	44.5	41.8	32.2	46.7	23.3	16.4	28.4
Бичиг үсэг мэддэг	8.4	5.7	10.1	13.1	8.3	15.4	4.6	2.9	5.9
Бичиг үсэг мэддэггүй	3.6	1.9	4.6	9.0	2.8	12.2	2.5	1.2	3.4

ХӨДӨӨ


Бичиг үсгийн мэдлэг, боловсролын төвшин	Насны бүлэг, хүйсээр								
	60-64			65-69			70-74		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Доктор	0.0	0.1	0.0	0.0	0.1	0.0	0.1	0.1	0.0
Магистр	0.2	0.4	0.1	0.1	0.3	0.0	0.0	0.1	0.0
Дипломын болон бакалаврын дээд	6.5	9.2	4.2	6.0	10.0	2.5	3.5	6.4	1.1
Тусгай мэргэжлийн дунд	11.1	10.4	11.6	7.5	9.0	6.1	5.0	7.5	2.9
Техник болон мэргэжлийн	3.1	4.4	1.9	2.1	3.3	1.0	1.6	2.7	0.8
Бүрэн дунд	10.9	12.6	9.5	7.1	9.1	5.3	4.7	6.6	3.1
Суурь	17.4	20.3	14.9	12.3	14.2	10.7	9.0	11.7	6.8
Бага	40.6	35.3	45.2	48.2	42.0	53.6	52.3	47.4	56.3
Бичиг үсэг мэддэг	7.0	5.3	8.4	11.3	8.9	13.4	15.6	12.4	18.4
Бичиг үсэг мэддэггүй	3.2	2.0	4.1	5.5	3.2	7.4	8.1	5.1	10.6

Хүснэгт 4.5-ын үргэлжлэл

Бичиг үсгийн мэдлэг, боловсролын төвшин	Насны бүлэг, хүйсээр								Бүгд	
	75-79				80+					
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй		
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	
Доктор	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.1	0.0	
Магистр	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.1	0.2	0.0	
Дипломын болон бакалаврын дээд	2.3	5.1	0.5	1.1	3.2	0.1	4.7	7.9	2.1	
Тусгай мэргэжлийн дунд	3.2	5.5	1.6	1.9	4.7	0.7	6.9	8.4	5.8	
Техник болон мэргэжлийн	1.1	2.0	0.5	0.5	1.4	0.1	2.0	3.2	1.0	
Бүрэн дунд	3.6	5.3	2.4	1.8	3.7	0.9	6.7	8.8	5.1	
Суурь	6.1	7.6	5.1	3.4	6.7	1.9	11.5	14.3	9.3	
Бага	50.3	47.3	52.4	42.7	46.5	41.0	46.4	41.9	49.9	
Бичиг үсэг мэддэг	22.9	21.6	23.9	28.6	25.4	30.1	14.2	11.2	16.5	
Бичиг үсэг мэддэггүй	10.4	5.6	13.7	19.9	8.5	25.3	7.5	3.9	10.3	

